ПРЕМИУМ БЬЮЛДИНГ
МАТЕРИАЛС ХХК

Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг
1 дүгээр хороо, Олимпийн гудамж 19А
Шангри-Ла Төв, Шангри-Ла Оффис
23 дугаар давхар, УБД 9011720047
(976) 7777-3311 info@premiumbm.mn

2024.10.23 № 1/318

Танай ____________-ны № ________________-т

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗАР
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТЭСТ

Тайлан хянан баталгаажуулах тухай

Премиум Бьюлдинг Материалс ХХК нь Нийслэлийн Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Үйлдвэрийн баруун бүс /16103/, Эрчим хүчний гудамж 57/1 тоот болон Нийслэлийн Баянзүрх дүүрэг, 10 дугаар хороо, Улиастайн гудамж А/101 тоот хаягуудад барилгын бэлэн бетон зуурмаг үйлдвэрлэх №1, №2 нэртэй төслийн үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд 2024 оны Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тайланг хүлээн авч, хянан баталгаажуулж өгнө үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А. ГАНБОЛД

*ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС ХХК-ИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН.*

Хянасан: НБОГ-ны ХБОБНХ-ын дарга: О.Тэмүүжин ……………………

НБОГ-ны ХБОБНХ-ын мэргэжилтэн: С.Сүхцоож ……………………

Хэрэгжилтийг гаргасан: Премиум Бьюлдинг Материалс ХХК –н

Гүйцэтгэх захирал: А.ГАНБОЛД

ХАБЭА, БО менежер: Л.ЭНХБАТ

# УЛААНБААТАР ХОТ БАЯНГОЛ ДҮҮРЭГ 20 ДУГААР ХОРОО, БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 10 ДУГААР ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭЛ №1, №2 НЭРТЭЙ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС ХХК –Н 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2024 ОН

АГУУЛГА

НЭГ Төслийн товч танилцуулга ........................................ 3

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ ........................................ 3

2.1. Тохиолдох магадлалын шалгуур үзүүлэлтүүд:........................................3

2.2. Үр дагаврын тодорхойлолт..............,........................................ 4

2.3. Нөлөөллийн үнэлгээний матриц ........................................ 4

2.4. Нөлөөллийн удирдлагын тайлбар ........................................ 4

2.5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ: ........................................ 5

2.6 Газрын хянан баталгаа ........................................ 5

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ........................................ 5

ДӨРӨВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........................................ 5

4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ........................................ 5

4.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах үеийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх ........................................ 6

4.3. Үйлдвэрээс гарах ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг хэрхэн байгаль орчинд халгүй аргаар устгах ........................................ 7

4.4. Орчны сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдсэн ажил: ........................................ 7

БГД-н 20 хороо үйлдвэрийн ногоон байгууламж ........................................ 8

Олон улсын Эко цэцэрлэгт хүрээлэнд 2 га газарт хийсэн ойжуулах төсөл........................................9

Олон улсын Эко цэцэрлэгт хүрээлэнд 2 га газарт хийсэн ойжуулах төсөл........................................10

Саарал ус хэрэглээ ........................................ 11

Хиймэл элс болон үнсний хэрэглээ ........................................12

БГД Агаар, хөрс, ус чанарын үзүүлэлтэд хийсэн судалгаа /6, 10 сар/ ..................,........................ 13

БЗД Агаар, хөрсний чанарын үзүүлэлтэд хийсэн судалгаа /6, 10 сар/ ........................................14

ХАВСРАЛТ ........................................

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Премиум Бьюлдинг Материалс" ХХК нь 2011 онд Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /16103/, Эрчим хүчний гудамж 57/1 тоотод олон улсын NRMCA-ийн сертификат бүхий "ZOOMLION-CIFA" бетон зуурмагийн үйлдвэрийг, 2017 онд хүчин чадал нэмэгдүүлэх зорилгоор IMER иж бүрэн автомат үйлдвэрийг нэмж ашиглалтад оруулан үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотын баруун хэсэгт /ТЭЦ4- ийн зүүн урд/ байрлах тус үйлдвэрүүд нь C50 (M600) хүртэлх маркийн бетоныг цагт 120 м3 үйлдвэрлэх хүчин чадалтай. Мөн нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 -р хороо, Улиастайн гудамж 101/A тоотод "ZOOMLION-CIFA" NZS120P дугаар бүхий бүрэн автомат үйлдвэрийг 2017 оноос угсралт суурилуулалт хийн ашиглаж байгаа бөгөөд тухайн үйлдвэрлэл явуулж байгаа үйлдвэрүүд нь орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон, үйлдвэрлэл явуулж байгаа бүс нь нэгдсэн харуул хамгаалалттай, ашиглаж байгаа зам талбай нь тусгайлан засаж бетон хучилт хийгдсэн түүхий эдийн агуулах талбай, явган болон авто зам, тэдгээрийн гэрэлтүүлэг, машин техникийн угаалгын хэсэг зэрэг нь дэлхийн жишигт нийцсэн үйлдвэрийн бүрдэл хэсгүүд юм.

## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Улаанбаатар хотын , Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /16103/, Эрчим хүчний гудамж 57/1 тоотод үйл ажиллагаагаа явуулж буй бетон зуурмагийн үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотголыг БОНХ-ын сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 тушаалаар баталсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал"- н дагуу матрицын үнэлгээний аргыг ашиглан 2018 онд, Баянзүрх дүүргийн 10 -р хороо, Улиастайн гудамж 101/A тоотод үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2017 онуудад тус тус эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн бөгөөд тус матрицын үнэлгээний арга дээр тулгуурлан Олон улсын туршлагад өргөн хэрэглэгдэж буй нөлөөллийн үнэлгээний үр дагавар болон тохиолдох магадлалын шалгуур үзүүлэлтүүдийн ашиглан байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр ангилан хийж гүйцэтгэсэн.

### 2.1. Тохиолдох магадлалын шалгуур үзүүлэлтүүд:

| Давтамжийн магадлал | | Магадлалын тодорхойлолт | Тохиолдох давтамж | Бодисын нөлөөнд өртөх |
|---|---|---|---|---|
| A | Маш өндөр | Төслийн/үйл ажиллагааны хугацаанд олон давтагддаг тохиолдол | Өдөр тутам тохиолддог | Бодисын нөлөөнд олон давтамжтай өртдөг (өдөр бүр). Ажлын байрны өртөлтийн хязгаараас (АБӨХ) 10 дахин их |
| B | Өндөр | Төслийн/үйл ажиллагааны хугацаанд олон давтагдах магадлалтай тохиолдол | Долоо хоногт 1-2 удаа тохиолддог | Frequent (daily) exposure at>OEL |
| C | Болзошгүй | Төслийн/үйл ажиллагааны хугацаанд тохиолдох магадлалтай | Сард 1-2 удаа тохиолддог | Frequent (daily) exposure at >50% of OEL; Infrequent exposure at > OEL |
| D | Бага | Төслийн/үйл ажиллагааны хугацаанд тохиолдох магадлал бага | Жилд 1-2 удаа тохиолддог | Frequent (daily) exposure at >10% of OEL; Infrequent exposure at > 50% of OEL |
| E | Ховор | Төслийн/үйл ажиллагааны хугацаанд тохиолдох магадлал маш бага | 3-5 жилд 1-2 удаа тохиолддог | Frequent (daily) exposure at >10% of OEL; Infrequent exposure at > 10% of OEL |

## 2.2. Үр дагаврын тодорхойлолт

| 1-Хөнгөн | 2-Дунд зэрэг | 3-Ноцтой | 4-Онц ноцтой | 5-Гамшгийн |
|---|---|---|---|---|
| Шууд нөлөөлөл | | | | |
| Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд хурдан хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой (Ажлын нэг хоногт) | Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд богино хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой (Долоо хоног) | Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд дунд хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой (Нэг сар) | Нөлөөллийн цар хүрээ нь орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүй бөгөөд удаан хугацааны нөхөн сэргээлт шаардагдана. Нөлөөлөл нь нөхөн сэргээгдэх боломжгүй хохирол үлдээнэ. (Олон жил) | Нөлөөллийн цар хүрээ нь орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүй маш өргөн хүрээнд тархах ба урт хугацааны нөхөн сэргээлт шаардана. Нөлөөлөл нь нөхөн сэргээгдэх боломжгүй ноцтой хохирол үлдээнэ. (Олон жил) |
| Шууд бус нөлөөлөл | | | | |
| Байхгүй | Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд хурдан хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой (Ажлын нэг хоногт) | Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд богино хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой (Долоо хоног) | Эх үүсвэр орчимдоо нөлөөлөл үүсгэх бөгөөд дунд хугацаанд бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой (Нэг сар) | Нөлөөллийн цар хүрээ нь орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүй бөгөөд удаан хугацааны нөхөн сэргээлт шаардагдана. Нөлөөлөл нь нөхөн сэргээгдэх боломжгүй хохирол үлдээнэ. (Олон жил) |

## 2.3. Нөлөөллийн үнэлгээний матриц

| Тохиолдох магадлал | | Үр дагавар | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1-Хөнгөн | 2-Дунд зэрэг | 3-Ноцтой | 4-Онц ноцтой | 5-Гамшгийн |
| A | Маш өндөр | Дунд | Их | Маш их | Маш их | Маш их |
| B | Өндөр | Дунд | Их | Их | Маш их | Маш их |
| C | Болзошгүй | Бага | Дунд | Их | Маш их | Маш их |
| D | Бага | Бага | Бага | Дунд | Их | Маш их |
| E | Ховор | Бага | Бага | Дунд | Их | Их |

### 2.4. Нөлөөллийн удирдлагын тайлбар

| Эрсдэлийн ангилал | Удирдлагын арга хэмжээ |
|---|---|
| Бага (Ангилал I) | Нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хэмжээнээс доогуур бөгөөд идэвхтэй арга хэмжээ авах шаардлагагүй. |
| Дунд (Ангилал II) | Нөлөөлөл нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнд бөгөөд байнгын хяналт тавих шаардлагатай |
| Өндөр (Ангилал III) | Нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн бөгөөд идэвхтэй арга хэмжээ авах шаардлагатай |
| Маш өндөр (Ангилал IV) | Нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хэмжээнээс маш ихээр хэтэрсэн бөгөөд нэн даруй анхаарал хандуулах, шуурхай арга хэмжээ авах шаардлагатай. |

### 2.5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ:

Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа Бетон зуурмагийн үйлдвэрийн эзэмшил талбай нь бүрэн хатуу хучилттай бөгөөд төслийн хүрээнд барилга угсралтын үйл ажиллагаа явагдаж дууссан тул хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэхээргүй байна. Үүний дээр бетон зуурмагийн үйлдвэр нь хот суурин түүний дотор аж үйлдвэрийн бүсэд орших ба төвийн шугам сүлжээнд холбогдсон тул зэрлэг амьтан болоод усан орчин үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй юм.

Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа Бетон зуурмагийн үйлдвэрийн эзэмшил талбай нь бүрэн хатуу хучилттай бөгөөд төслийн хүрээнд барилга угсралтын үйл ажиллагаа явагдаж дууссан тул хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэхээргүй байна.

Үзүүлж болзошгүй гэж дүгнэгдсэн үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь түүхий эдийг бункерт зөөж хийх үед тоосжилт үүсэх, ачигч болон миксер бүхий тээврийн хэрэгслээс ялгарах хорт утаа ялгарах, химийн бодисын хадгалалт, ашиглалтын явцад ууршимтгай дэгдэмхий нэгдлүүд агаарт уурших, асгарч болох зэргээр үйлдвэрийн гадаад орчны агаарын чанарт сөрөг нөлөө, гадаад орчны агаарын чанар муудсанаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.

### 2.6 Газрын хянан баталгаа

“Премиум Бьюлдинг Материалс” ХХК нь 2022 оны 12 – р сард БЗД -н 10 -р хорооны өөрийн эзэмшил газрын бетон зуурмагийн үйлдвэрийн газарт “газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа” -г Дорнын Байгаль ХХК -р хийлгэсэн. 2020 оны 6-р сард БГД-н 20-р хорооны өөрийн эзэмшил газрын бетон зуурмагийн үйлдвэрийн газарт “газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа” -г Гео Интегрейшн ХХК -р хийлгэсэн.

## ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Премиум Бьюлдинг Материалс” ХХК нь төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд 2024 онд багтаан ISO 14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартын магадлан аудитын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажилласан.

## ДӨРӨВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

| № | Сөрөг нөлөөлөл | Биелэлт |
|---|---|---|
| 1 | • Химийн бодис материалын хадгалалтын нөхцөлийн стандартыг нарийн баримталж уурших, халах, тэлэх нөхцөлөөс бүрэн сэргийлж ажиллах; | • Бетон зуурмаг хэрэглэгдэх химийн нэмэлт бодисуудыг харилцагч байгууллагаас гэрээний дагуу захиалгаар авдаг бөгөөд шингэн төлөвтэй бодисуудыг стандарт шаардлагад нийцсэн савлагаатай авдаг бөгөөд ирсэн нэмэлт бодисыг үйлдвэрийн бүрдэл хэсэг болох 8 тн багтаамжтай битүү саванд хийгдэж ашиглагддаг |
| 2 | • Хатуу хог хаягдлыг шатаахыг хориглож ажиллах; | • БГД, БЗД-н тохижилт үйлчилгээний компаниудтай хог хаягдлыг тээвэрлэх гэрээг байгуулсан бөгөөд тогтмол хугацаанд хог хаягдлыг ачуулдаг |
| 3 | • Үйлдвэрийн гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээг тогтмол хийлгэж байх; | • Цаг уур, орчны шинжилгээний газрын байгаль орчин хэмжилзүйн төв лабораторид MNS 17.2..12:88, MNS 17.2.5.11588, DUSTRAK8530 стандартуудын дагуу үйлдвэрийн гадаад орчны агаарын чанарын шинжилгээг 6,10 саруудад хийлгэсэн |
| 4 | • Хадгалагдах химийн бодисуудын ууршилтын байдалд байнга хяналт тавьж, ажлын байрны болон агуулахын ойр орчмын агаарын чанар муудсан шинж тэмдэг илэрвэл тухай бүрт нь байгаль орчны болон мэргэжлийн хяналтын байгууллагуудад мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг нэн даруй авах; | • Хадгалагдах химийн бодисуудын ууршилтын байдалд байнга хяналт тавьж, ажлын байрны болон агуулахын ойр орчмын агаарын чанар муудсан шинж тэмдэг илрээгүй |
| 5 | • Техник хэрэгслүүдийн урсгал засварыг цаг тухайд нь хийж байх мөн тэдгээрийн үзлэг оношилгоог хуулийн хугацаанд явуулах; | • Үйлдвэрийн ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүд нь батлагдсан хуваарийн дагуу засвар үйлчилгээ тогтмол хийгдэж байгаа |
| 6 | • Орчны тоосжилтыг бууруулах | • БГД 20 хороо үйлдвэрийн доторх цэвэрлэгээг долоо хоног тутамд хийгддэг.<br>• БГД -н 20 хороо үйлдвэрийн орох хэсэгт бороонь ус цуглуулах худаг 5-р сард шинээр хийгдсэн цуглуулагдсан усаар зам талбайн усалгаа хийгддэг болсон. |
| 7 | • Байгалийн эко тэнцвэрт байдлыг хангах | • 2024 оны 10 сард Грийн Дрийм ХХК -тай хамтран Богд хан уулын Энхтайван аманд 1 га талбайд Шинэс, Хуш, Хус моднуудыг суулгаж ойжуулах ажилбарыг хамтран гүйцэтгэсэн. |

### 4.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах үеийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх

| | | |
|---|---|---|
| **1** | Химийн хорт болон аюултай химийн бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгална. | ХАБЭА,БО-008 Химийн бодистой харьцаж ажиллах, хадгалах журам хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| **2** | Химийн хорт болон аюултай бодисын агуулахыг хүн ам оршин суугаа газраас 300-аас доошгүй метрийн зайд, үер усанд автахааргүй байрлалд байрлуулах ба агуулах нь галд тэсвэртэй материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шат (цементэн болон плита), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалга, үерийн далан, хамгаалалтын сувагтай байна. | Химийн нэмэлтийн сав нь үл нэвчих гадаргуйтай /бетон шал/, асгаралт /ослын/-ын үед байгаль орчинд алдагдахаас хамгаалсан суваг, шуудуй бүхий ваннтай. |
| **3** | Химийн бодисын нэг агуулахад 500 тонноос, агуулахын доторх нэг тасалгаанд 50 тонноос ихгүй бодис хадгална. | ХАБЭА,БО-008 Химийн бодистой харьцаж ажиллах, хадгалах журам хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| **4** | Шингэн химийн бодисыг хагардаггүй эсвэл бат бөх хагардаггүй давхар савлагаатай саванд хадгалах ба хадгалах агуулахын температур нь тухайн бодисын хадгалах нөхцөлд тохирсон байвал зохино | Бетоны чанар, бат бэхийн үзүүлэлт болон нэмэлтийн бүтээгдэхүүний чанарыг өдөр тутам лабораторт дээж өгч хянуулдаг. |
| **5** | Агуулах нь хадгалж буй бодисын ангилал, нэр төрөл, тоо хэмжээг тусгасан байнгын бүртгэлтэй байна. | Химийн нэмэлтийн ашиглалтын бүртгэл хөтлөн, ХАБЭА,БО-008 Химийн бодистой харьцаж ажиллах, хадгалах журам хэрэгжүүлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. |

**2023-2024 оны үйлдвэрүүд дээр хэрэглэсэн нэмэлтийн хэрэглээ /тн/**

| № | Химийн нэмэлтийн нэр төрөл | | 2023 он | | | | 2024 он | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | BP1 | BP2 | BP3 | BP4 | BP1 | BP2 | BP3 | BP4 |
| 1 | Сика вискокрет 5510 | Sika Visko Crete 5510 | 530 | 270 | 80 | 32 | 290 | 180 | 110 | 70 |
| 2 | Сика вискотайт | Sika Visko Tight | 30 | 11 | | | 9.5 | 7.5 | 1 | |
| 3 | Сика Аэр 50 | Sika Aer- 50 | 6 | 0.5 | | 3.8 | 2 | 0.2 | | 6.9 |
| 4 | Сика Рапид 1 | Sika Rapid -1 | 50 | 2.3 | | | 1.4 | 0.1 | | |

**4.3. Үйлдвэрээс гарах ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг хэрхэн байгаль орчинд халгүй аргаар устгах**

| | | |
|---|---|---|
| **1** | Хаягдал бүтээгдэхүүнийг дахин боловсруулах зах зээлд нийлүүлэх. | - ХАБЭА,БО-011 Хог хаягдлыг ангилах ялгах, шилжүүлэх журам боловсруулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилллаж байна.<br>- Хог хаягдлыг ангилах“ЭС И ЭС ЭЛ СМАРТ СОЛЮШН”ХХК-тай 2024/05/21 SESL/24 тоот гэрээ байгуулан, хуванцар сав, гялгар уут зэргийг дахин боловсруулах үйлдвэрлэлд нийлүүлж байна. |
| **2** | Үйлдвэрийн талбайд хог, хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, зөвшөөрөгдсөн цэгт дарж булах ажлыг мэргэжлийн компаниар гүйцэтгүүлж байх. | - Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-тай 24/107 тоот гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. |
| **3** | Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарч буй бүхий л төрлийн дахин ашиглагдах боломжтой хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж зориулалтын сав, тусгайлан бэлдсэн талбайд цуглуулах. | - ХАБЭА,БО-011 Хог хаягдлыг ангилах ялгах, шилжүүлэх журам боловсруулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.<br>- Ангилан ялгалтын хогийн савийг үйлдвэрлийн бүсэд байршуулж, өнгөний кодоор ялган хаягжуулж ажилллаж байна. |
| **4** | Ангилан ялгаж цуглуулсан хог хаягдлыг хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд халгүйгээр цуглуулах, үйлдвэрийн талбайгаас зайлуулах зорилгоор хог хаягдлыг нэгдсэн цэгт эмх цэгцтэй төвлөрүүлэн хадгалах. | - ХАБЭА,БО-011 Хог хаягдлыг ангилах ялгах, шилжүүлэх журам боловсруулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. |
| **5** | Хог, хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах, цуглуулах, хадгалахтай холбоотой дотоод журмуудыг боловсруулан, өдөр тутамдаа мөрдлөг болгон хэрэгжүүлэх. | - ХАБЭА,БО-011 Хог хаягдлыг ангилах ялгах, шилжүүлэх журам боловсруулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.<br>- Журмын хэрэгжилтийг өдөр тутам хангаж, “Ажлын байрны үзлэг”-ийг 7 хоног бүр хийж, хяналт тавьдаг. |
| **7** | Хог хаягдалтай холбоотой журмуудыг үйлдвэрийн нийт ажилчдад таниулах, хог хаягдлыг ангилан ялгах дадал соёлыг хэвшүүлэх сургалтыг тогтмол явуулах. | - ХАБЭА, Байгаль орчны сургалты зохион байгуулах, шалгалт авах журам боловсруулж, жилд бүр тогтмол дотоод журмын сургалтыг зохион байгуулдаг. |
| **8** | Ажлын байрны үзлэг шалгалтыг тогтмол хийж, журмуудыг хэрэгжилтийг хангаж байгаа байдалд хяналт тавих. | - ХАБЭА,БО -015 Ажлын байрны үзлэг, шалгалт хийх журмыг 2024/02/21 өдрөөс хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| **9** | Компанийн үйл ажиллагаанаас гарсан нийт хог хаягдал болон дахин ашигласан хог хаягдлын хэмжээг тогтмол бүртгэж, долоо хоног болон сарын тайландаа тусгах. | - Хог хаягдал шилжүүлэх бүртгэл хөтлөн ажилладаг. |
| **10** | Хоёрдогч түүхий эд дахин боловсруулдаг, бэлтгэдэг, цуглуулдаг, тээвэрлэдэг, зах зээлд нийлүүлдэг иргэд, байгууллага, үйлдвэрүүдэд худалдан борлуулах, нийлүүлэх замаар үйлдвэрийн талбайгаас зайлуулах ажлыг гүйцэтгэх. | Хог хаягдлыг ангилах“ЭС И ЭС ЭЛ СМАРТ СОЛЮШН”ХХК-тай 2024/05/21 SESL/24 тоот гэрээ байгуулан, хуванцар сав, гялгар уут зэргийг дахин боловсруулах үйлдвэрлэлд нийлүүлж байна. |

**4.4. Орчны сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдсэн ажил:**

БГД -н 20 -р хороо үйлдвэрийн оффис болон үүдний хэсэгт 1245 м2 ногоон байгууламжид “Грийн Дрийм” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан арчилгааг тогтмол давтамжтай хийж үр дүнг тооцож ажилласан.

2024 оны 10 сард “Тансаг Ландшафт” ХХК-тай хамтран Баянзүрх дүүргийн олон улсын Эко цэцэрлэгт хүрээлэнд дахин 2 га талбайд Гацуур 5 ш, Хус мод 11ш, Агч мод 36ш, Нарс мод 3ш, Голтбор 21ш, Тэхийн шээг 7ш, Үхрийн нүд 27ширхэгийг суулгаж ажилласан. Өмнөх жилүүдэд Ногоон хишигтэн ТББ-тай гэрээлэн Богд уулын аманд ойжуулах ажлыг хийсэн бөгөөд нийт 3га газарт  Шинэс, Хуш, Хус зэрэг моднуудын суулгацыг тарьж ургуулж ажилласан бөгөөд суулгацын амьдралтын хувь 95% тай ургаж байна.

2024 онд нийт 2 удаагийн давтамжтай БГД-н 20 хороо болон БЗД-н 10 хороонд байрлах бетон зуурмагийн үйлдвэрүүдэд /06, 10 –р саруудад/ хөрс, ус, агаарын чанарын шинжилгээг Байгаль орчин хэмжилзүйн төв лабораториор хийлгэж үр дүнг харьцуулан ажилласан.

**БГД-н 20 хороо үйлдвэрийн ногоон байгууламж**






*ПРЕМИУМ БЬЛДИНГ МАТЕРИАЛС ХХК-ИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН.*





**Олон улсын Эко цэцэрлэгт хүрээлэнд 2 га газарт хийсэн ойжуулах төсөл.**


ТЭРБУМ МОД

БАТЛАМЖ

Премиум бьюлдинг материалс ТАНАА

«Арчлахгүй бол ургахгүй» уриан дор намрын бүх нийтийн мод тарилтын өдөр «Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн»-ийн талбайд мод тарьж бидний үйл ажиллагааг дэмжин оролцож ногоон ирээдүйг бүтээсэн танай хамт олонд талархал илэрхийлье.

«Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн» ОНӨҮГ-ын

ЗАХИРАЛ Б.САЙНЖАРГАЛ

Төслийн танилцуулга видеог эндээс үзнэ үү

2024 ОН









**Саарал ус хэрэглээ**

БЗД болон БГД -н бетон зуурмагийн үйлдвэрүүдэд технологийн тээврийн хэрэгслийг угаасан усыг 3 дамжилгат тунгаагуурт тунгааж саарал усыг технологийн тээврийн хэрэгсэл угаах, зам талбайн усалгаанд дахин ашиглаж байна. Мөн тусгай төхөөрөмжөөр технологийн тээврийн хэрэгсэл угаасан хаягдлаас элс дайргыг ялган авч дотоод хэрэгцээндээ ашиглаж байна



*ПРЕМИУМ БЬЛДИНГ МАТЕРИАЛС ХХК-ИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН.*





2024 оны 4 -р сараас 9-р сарын хооронд нийт 6 сарын хугацаанд **8460 тн** саарал усыг технологийн тээврийн хэрэгсэл угаах болон зам талбайн усалгаанд дахин ашигласан байна.

| Сар | Бетон зуурмагын тоо хэмжээ | Рейсийн тоо | 1 удаагийн угаалтанд зарцуулах ус /тн/ | 1 сард миксер угаахад зарцуулах усны хэмжээ /тн/ |
|---|---|---|---|---|
| 4 | 16710 | 2089 | 0,5 | 1044 |
| 5 | 23094 | 2887 | 0,5 | 1443 |
| 6 | 25695 | 3212 | 0,5 | 1606 |
| 7 | 24074 | 3009 | 0,5 | 1505 |
| 8 | 21944 | 2743 | 0,5 | 1372 |
| 9 | 23850 | 2981 | 0,5 | 1491 |
| Нийт | 135367 | 16921 | | 8460 |

2024 оны 1-р сараас 9-р сар хүртэл нийт **6624.63 тн** үнс ашигласан байна.

Үйлдвэр 1 болон 2т Хөрс, агаар, усны чанарын шинжилгээг Цаг уур, орчны шинжилгээний газар Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид 2024 оны 5 болон 10 саруудад хийлгэсэн.

Баянгол дүүрэг 20-р хороо үйлдвэр1 хөрс, ус, агаарын чанарт хийсэн шинжилгээ.

| **ХӨРС /BP#1/** | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Кадьми** | **Хар тугалга** | **Мөнгөн ус** | **Хром** | **Цайр** | **Зэс** | **Стронци** |
| **Утга** | **3** | **100** | **2** | **150** | **300** | **100** | **800** |
| 13/5/2024 | <0.05 | 16 | <0.005 | <0.5 | 108 | 29 | 327 |
| | 0.2 | 15 | <0.005 | <0.5 | 69 | 30 | 361 |

| **АГААР /BP#1/** | | | | |
|---|---|---|---|---|
| | **Хүхэрлэг хий** | **Азот давхар исэл мг/м3** | **Нийт тоос мг/м3** | **Дуу чимээ** |
| **Утга** | **0.45** | **0.2** | **0.5** | **60** |
| 13/5/2024 | 0.01 | 0.028 | 0.71 | 60 |
| | 0.009 | 0.019 | 0.362 | 48 |

| **УС /BP#1/** | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **pH** | **EC** | **SO4** | **CI** | **Ca** | **Mg** | **Na+K** | **HCO3** | **Эрд** | **Хат** |
| **Утга** | **6.5-8.5** | **1000** | **100** | **30** | **0** | **500** | **-** | **-** | **-** | **7** |
| 28/6/2024 | 6.84 | 260 | 39.9 | 12.4 | 36.9 | 2.2 | 17.5 | 93.9 | 203 | 2.02 |

| **УС /BP#1/** | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Ж/б** | **ПИЧ** | **NH4** | **NO2** | **NO3** | **PO4** | **Fe** | **F** |
| **Утга** | **-** | **-** | **1.5** | **1** | **50** | **3.5** | **0.3** | **0.7-1.5** |
| 28/6/2024 | 0.8 | 1.5 | 0.03 | 0.006 | 6.56 | 0.016 | 0.01 | 1.42 |

Баянзүрх дүүргийн 10-р хороо үйлдвэр2 хөрс агаарын чанарт хийсэн шинжилгээ.

| ХӨРС /BP#2/ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Кадьми** | **Хар тугалга** | **Мөнгөн ус** | **Хром** | **Цайр** | **Зэс** | **Стронци** |
| **Утга** | **3** | **100** | **2** | **150** | **300** | **100** | **800** |
| 13/5/2024 | <0.05 | 18 | <0.005 | <0.5 | 29 | 30 | 638 |

| АГААР /BP#2/ | | | | |
|---|---|---|---|---|
| | **Хүхэрлэг хий** | **Азот давхар исэл мг/м3** | **Нийт тоос мг/м3** | **Дуу чимээ** |
| **Утга** | **0.45** | **0.2** | **0.5** | **60** |
| 13/5/2024 | 0.011 | 0.024 | 0.226 | 74 |

## Хавсралт

Хууль зүйн сайдын 2016 оны А/204 дугаар тушаалаар батлав

МОНГОЛ УЛС

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

000134662

2018.01.12
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011720047
/ Хувийн хэргийн дугаар /

6266258
/ Регистрийн дугаар /

Премиум бьюлдинг материалс Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол — 18/01 — 2018.01.11
/ шийдвэрийн нэр / — / дугаар / — / он, сар, өдөр /

| / код / | / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 4663 | Барилгын материалын худалдаа |
| 4610 | Гадаад худалдаа |
| 4510 | Автомашины худалдаа |

/ код / — / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй — 1 — 1,000.0
/ хугацаа / — / гишүүдийн тоо / — / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, юнеско, МПМ цогцолбор, 12 давхарт, Утас1: 88884545, Утас2: 77773311, Факс: 976-70122292
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

МОНГОЛ УЛС

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Адилбиш овогтой Ганболд-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.* | 2018.01.12 | Г.Алтай |
| 1 | ***Өврийн хөрөнгийн хэмжээ 7551177 мян.төг-р нэмэгдэж нийт 7552177 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.*** | 2018.03.23 | Э.Эрдэнэбилэг |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

*0001346 62*

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ, АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ**

# ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2023-08-03 Дугаар: 0002512 Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС ХХК
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9011720047
Регистрийн дугаар: 6266258
Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпийн, 19а, Шангри-Ла төв, оффис, 23 давхарт

Утас: 88884545, 77773311

**Дараах химийн хортой, аюултай бодис:**

Импортлох, ашиглах, худалдах **тусгай зөвшөөрлийг**
2023.08.03 -2028.08.03 **хүртэл хугацаагаар олгов.**

| № | Бодисын нэр | | Томъёо | Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/ | Ангилал | Үйлдвэрлэсэн улс | Хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Монгол | Олон улсын | | | | | |
| 1 | Хавсралтад дурдсан 20 нэр төрөл бодис | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |
| 6 | | | | | | | |
| 7 | | | | | | | |
| 8 | | | | | | | |

**Улсын хилээр нэвтрүүлэх боомт:** Сүхбаатар, Алтанбулаг, Замын Үүд, Бичигт, Баянхошуу, Гашуунсухайт, Чингис хаан

**Зөвшөөрөл олгосон:** **Байгаль орчин, аялал жуулчлалын яам**
**Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр**
орлон гүйцэтгэгч / С.ЦОГТ-ЭРДЭНЭ /

**Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн**
/ Ц.БАТЖАРГАЛ /

**Химийн хорт болон аюултай бодисыг
Импортлох, ашиглах, худалдах 0002512
дугаартай тусгай зөвшөөрлийн хавсралт**

| № | Монгол нэр | Олон улсын нэр | Томъёо | CAS дугаар | Зөвшөөрсөн хэмжээ, тн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сика Вискокрет-5500 | Sika ViskoCrete-5500 | - | 27599-56-0 | 25 |
| 2 | Сика Вискокрет-5510 | Sika ViskoCrete-5510 | - | 27599-56-0 | 9000 |
| 3 | Сика Вискокрет-5520 | Sika ViskoCrete-5520 | - | 27599-56-0 | 100 |
| 4 | Сика Вискокрет-5540 | Sika ViskoCrete-5540 | - | 27599-56-0 | 6760 |
| 5 | Сика Вискокрет-5520W | Sika ViskoCrete-5520W | - | 27599-56-0 | 100 |
| 6 | Сика Вискокрет-WR14 | Sika ViskoCrete-WR14 | - | 27599-56-0 | 100 |
| 7 | Сика Вискотайт | Sika Visko Tight | - | 27599-56-0 | 250 |
| 8 | Сика Аэр-50 | Sika Aer-50 | - | 9004-82-4 | 225 |
| 9 | Сика Рапид-1 | Sika Rapid-1 | - | 7631-99-4 | 400 |
| 10 | Силика Фюм | SikaFume | - | 7631-86-9 | 9250 |
| 11 | Сика Ретардол-25 | Sika Retardol-25 | - | 14265-44-2 | 25 |
| 12 | Сика тогтворжуулагч | Sika Stabilizer | - | 9005-84-9 | 5 |
| 13 | Сика Файбер Хүч PP44-65 | Sika Fiber Force PP 44-65 | - | 9003-07-0 | 2500 |
| 14 | Сика Тард 960HC | Sika Tard 960HC | - | 59-50-7<br>26530-20-1 | 1500 |
| 15 | Сика Памп старт 1 | Suka Pump start-1 | - | 56-81-5<br>26530-20-1 | 300 |
| 16 | Сигунит L54 AF | Sigunit L54 AF | - | - | 16000 |
| 17 | Сика UCS | Sika UCS | - | 7631-86-9<br>231-545-4 | 25 |
| 18 | Интрапласт-Z | Intraplast-Z | - | 471-34-1<br>497-19-8 | 5 |
| 19 | Пронал-753 | Pronal-753 | - | - | 1 |
| 20 | Сика Файбер Sika | Sika Fiber 3 | - | - | 15 |

0008286

## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар МУ 16-051/21

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" Монгол Улсын хуулийг үндэслэн Улаанбаатар аймаг/нийслэлийн Баянгол сум/дүүргийн " Премиум бюльдинг материалс " ХХК -д

9011720047 /улсын бүртгэлийн дугаар/

6266258 /регистрийн дугаар/

Материалын үйлдвэрлэл: 4.2 заалтын дагуу сунгах

ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 06 -р сарын 08 -ны өдрөөс таван жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД** **Б.МӨНХБААТАР**

2021 он 06 сар 08 өдөр

Улаанбаатар хот

***Ажил, үйлчилгээний төрөл:***

МҮ-4.2 Бетон зуурмагийн үйлдвэр

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг: Улаанбаатар хот, БГД, 20-р хороо

/IMER-13090171, S Couvrot-100123 MT/

Компанийн захирал /эзэн/ А.Ганболд /овог, нэр/

Утас: 88886651 Факс: 70143311 70122292 И-мэйл: info@premiumgroup.mn

0008288

## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар МУ 13-052/21

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" Монгол Улсын хуулийг үндэслэн Улаанбаатар аймаг/нийслэлийн Баянзүрх сум/дүүргийн " Премиум бюльдинг материалс " ХХК -д

9011720047 /улсын бүртгэлийн дугаар/

6266258 /регистрийн дугаар/

Материалын үйлдвэрлэл: 4.2 заалтын дагуу сунгах

ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 06 -р сарын 08 -ны өдрөөс таван жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Б.МӨНХБААТАР

2021 он 06 сар 08 өдөр

Улаанбаатар хот

***Ажил, үйлчилгээний төрөл:***

МҮ-4.2 Бетон зуурмагийн үйлдвэр

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг: Улаанбаатар хот, БЗД, 10-р хороо

/IMER-13090170, TRUE MAX-516017/

Компанийн захирал /эзэн/ А.Ганболд

/овог, нэр/

Утас: 88886651 Факс: 70143311 70122292 И-мэйл: info@premiumgroup.mn

## ГЭРЭЭНИЙ ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН ХУУДАС

ЗАРЛАГЫН ГЭРЭЭ

Компанийн нэр: PBM-PD - 2024/0086
Гэрээний төрөл: Ажил гүйцэтгэх гэрээ

| | | |
|---|---|---|
| Гэрээний хураангуй | | НОГООН БАЙГУУЛАМЖИД МОД ТАРИХ, АРЧИЛГАА ХИЙХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ |
| **1. ГЭРЭЭЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ** | | |
| | Нэр: | ГРИЙНДРИЙМ ХХК |
| | Регистрийн дугаар: | 5472857 |
| | Хаяг: | Улаанбаатар Сонгинохайрхан 1-р хороо бизнес тауэр 607 |
| | Утас: | 99114649 |
| | Данс: | ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК \| 499209933 \| Төгрөг |
| | НӨАТ төлөгч эсэх : | Үгүй |
| **2.ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ** | | |
| | Гэрээний нэр: | Ажил гүйцэтгэх гэрээ-Стандарт |
| | Гэрээний зүйл: | |
| | Гэрээний хугацаа: | Эхлэх хугацаа: 2024-04-15 Дуусах огноо : 2024-10-31 |
| | Автоматаар сунгагдах эсэх: | Үгүй |
| | Гэрээний чиглэл: | |
| **3. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ** | | |
| | Төлбөрийн давтамж: | Гүйцэтгэлээс хамааран |
| | Нийт төлбөр: | 10,000,000.00 (MNT) |
| | Төлбөрийн хэлбэр: | Бэлэн бус |
| | Татварын мэдээлэл: | |
| | Төсөвтэй эсэх: | Тийм |
| | Төсвөөс хэтэрсэн эсэх: | Үгүй |
| | Төлбөр төлөх хуваарь: | Төрөл / Хувь / Дүн / Валют<br>Нийт гэрээний төлбөр / 100.00 / 10,000,000.00 / MNT |
| | Алданги, торгууль: | Үндэслэл / Хувь |
| **4. БУСАД** | | |
| | Нэмэлт гэрээ эсэх: | Байхгүй - |
| | Өөрчлөгдсөн нөхцөл: | |
| | Нэмэлт тайлбар: | |
| | Өмнө гэрээ байгуулж байсан эсэх | Үгүй |
| **5. ХЯНАЛТЫН САМБАР** | | |
| | Худалдан авалтын удирдлага | З.Намуун/Худалдан авалтын менежер/ 2024-07-30<br>ok |
| | Худалдан авалтын захирал | П.Мөнхнасан/Managing Director/ 2024-07-31<br>саналгүй |

БАТЛАВ:
“ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС”
ХХК – ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

А.ГАНБОЛД

БАТЛАВ:
“ГРИЙН ДРИЙМ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ОРГИЛ

**НОГООН БАЙГУУЛАМЖИД МОД ТАРИХ, АРЧИЛГАА ХИЙХ**
**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**
№ 24/03-02
PBM- PD-2024/0086

---

“ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС” ХХК
болон
“ГРИЙН ДРИЙМ” ХХК

---

**Захиалагч:**

**“ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС ” ХХК**
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, 19А, Шангри-ла оффис, 23-р давхар

Утас: (976-11) 7777-3311
Имэйл хаяг:
info@premiumconcrete.mn

**Гүйцэтгэгч:**

**“ГРИЙН ДРИЙМ” ХХК**
Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 10Б, Бизнес тауэр оффис, 607 тоот

Утас: (976) 9911-4649
Имэйл хаяг:
orgil@greendream-mongolia.com

Улаанбаатар хот
2024 он

## НОГООН БАЙГУУЛАМЖИД МОД ТАРИХ, АРЧИЛГАА ХИЙХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2024 оны 04-р сарын 15-ны өдөр №  Улаанбаатар хот

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, 23-р давхарт байрлах 6266258 регистрийн дугаартай “Премиум Бьюлдинг Материалс” ХХК (цаашид “Захиалагч” гэх)-ийг төлөөлж Худалдан авалтын албаны менежер З.Намуун,

1.2 Нөгөө талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 10Б байр, Бизнес тауэр оффисын 607 тоот хаягт байрлалтай “ГРИЙН ДРИЙМ” ХХК / цаашид “Гүйцэтгэгч” гэх/, түүнийг төлөөлж Захирал Б.Оргил /цаашид хамтад нь “Талууд” гэх/

1.3 Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт байрлах Бетон зуурмагийн үйлдвэр төслийн ногоон байгууламжийн арчилгаа, нэмэлт тарилтын ажлыг гүйцэтгэхээр харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав. Үүнд:

1.3.1 Хавсралт№1 Бетон зуурмагийн үйлдвэрийн ногоон байгууламжид хийгдэх нөхөн тарилт, арчилгааны график

1.3.2 Хавсралт№2 Гэрээт ажлын дэлгэрэнгүй задаргаа

1.4 Талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний үүргээ бүрэн биелүүлснээр гэрээ дуусгавар болно.

### ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

2.1 Ногоон байгууламжийн талаарх холбогдох мэдээлэл арчилгаа хийхэд шаардлагатай баримт, мэдээллээр Гүйцэтгэгчийг хангана.

2.2 Захиалагч нь гүйцэтгэгчийн хийсэн ажлыг актаар баталгаажуулан хүлээн авна

2.3 Захиалагч Гэрээний үнийг гэрээний 4 дүгээр зүйлд заасан нөхцөлийн дагуу төлнө.

2.4 Захиалагч нь Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр хэдийд ч ажлын явц гүйцэтгэлтэй танилцах, өөрийн саналыг Гүйцэтгэгчтэй тохиролцон тайланд оруулах эрхтэй.

### ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1 Гүйцэтгэгч нь хийгдсэн ажлын тайланг гэрээгээр тогтоосон хугацаанд Захиалагчаас тавьсан шаардлагад нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд чанартай хийж гүйцэтгэнэ.

3.2 Гүйцэтгэгч нь Гэрээгээр тогтоосон төлбөрийг гэрээнд заасан журмын дагуу хугацаанд нь төлөхийг Захиалагчаас шаардах эрхтэй.

3.3 Гэрээт ажил гүйцэтгэх газарт ажиллахдаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг бүрэн хангаж ажиллах ба энэ үүргээ биелүүлээгүйгээс үүсэх хохирол, хариуцлагыг Гүйцэтгэгч тал бүрэн хүлээнэ.

3.4 Гүйцэтгэгчийн ажилчид нь Гэрээт ажлыг гүйцэтгэх хангалттай дадлага туршлагатай мэргэжлийн хүмүүс байх ба Гэрээт ажлыг гүйцэтгэх явцдаа Захиалагч болон Гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

3.5 Гүйцэтгэгч нь Захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр гэрээт ажлыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

3.6 Захиалагчаас ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан шаардлага гаргах буюу санал, заавар, дүгнэлт өгвөл хүлээн авах, тусгах, биелүүлэх үүрэгтэй.

3.7 Захиалагч гэрээт ажлыг доголдолтой гэж үзэн хүлээж авахаас татгалзвал Захиалагчийн тогтоосон хугацаанд өөрийн зардлаар засах буюу шинээр гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд үүний улмаас Захиалагчид учирсан бодит хохирлыг хариуцан арилгах үүрэгтэй.

## ДӨРӨВ. ХУГАЦАА

4.1 Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт байрлах Бетон зуурмагийн үйлдвэр төслийн ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн сэргээлтийн ажлыг дараах хугацаанд хийж гүйцэтгэнэ.

4.2 2024 оны 4-р сар төслийн талбайн ногоон байгууламжийн цэвэрлэгээ, хайлаас шилжүүлэн суулгах, мод бут сөөг шинээр тарих.

4.3 2024 оны 6-р сараас 8-р сарын хооронд төслийн талбайн зүлэг тариалалт, навчит модны хэлбэржүүлэлт, ургамлан хашлагад бэхжүүлэлт хийх.

4.4 2024 оны 9-р сар төслийн талбайн ногоон байгууламжийн цэвэрлэгээ.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛӨХ НӨХЦӨЛ

5.1 Гэрээний нийт үнийн дүн 10 000 000 төгрөг /арван сая/ төгрөг байх бөгөөд Гүйцэтгэгчийн ажлын хөлс болон НӨАТ багтсан болно.

5.2 Ажлын урьдчилгаа төлбөрт Гэрээний 5.1дэх хэсэгт заасан төлөх төлбөрөөс урьдчилгаа 5,000,000 төгрөг (Таван сая) төгрөгийг гэрээ баталгаажсаны дараа ажлын 5 хоногийн дотор

5.3 Гэрээний 5.1 дах хэсэгт заасан нийт мөнгөний төлбөрийн үлдэгдэл 5 000 000 (таван сая) төгрөгийг Ажил бүрэн гүйцэт дуусч тооцоо нийлсэн акт, ажил хүлээлцсэн акт, ажлын тайлан зэргийг хүлээн авснаас хойш ажлын 5 (тав) хоногийн дараа тус тус төлнө.

## ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1 Хоёр тал гэрээнд заагдсан үйл ажиллагаанд холбогдсон асуудлаар маргаанд хүрвэл тохиролцлын үндсэн дээр шийдвэрлэхийг зорих бөгөөд ойлголцолд үл хүрвэл хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх эрхийг тэгш эдэлнэ.

6.2 Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

6.3 Гэрээг Монгол хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж, Захиалагч нэг, Гүйцэтгэгч нэгийг хадгалах бөгөөд гэрээний хувиуд хуулийн адил хүчинтэй байна.

6.4 Мэдэгдэл хүргүүлэх: Энэхүү Гэрээнд дурдсан аливаа мэдэгдэл нь бичгэн хэлбэрээр байна. Мэдэгдлийг Гэрээний тусгай нөхцөлд дурдсан хаягаар эсвэл тухай бүр мэдэгдсэн бусад хаягаар биеэр авчирч өгөх буюу шуудангаар эсвэл Захиалагчаас зөвшөөрсөн тохиолдолд и-мэйлээр илгээнэ.

6.5 Гэрээний тусгаар байдал: Гэрээний аль нэг заалт(ууд) нь хуулийн дагуу хүчин төгөлдөр бус байх тохиолдолд гэрээний бусад заалтууд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

6.6 Нэмэлт, өөрчлөлт: Талуудын бичгээр харилцан тохиролцож гарын үсэг зурсны үндсэн дээр энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| **Захиалагчийг төлөөлж:** | **Гүйцэтгэгчийг төлөөлж:** |
| “Премиум Бьюлдинг Материалс” ХХК-ийн Худалдан авалтын албаны менежер | “Грийн Дрийм” ХХК –ийн Захирал |
| ______________ | ______________ |
| З.Намуун | Б.Оргил |

## Хавсралт №1- Бетон зуурмагийн үйлдвэрийн ногоон байгууламжид хийгдэх нөхөн тарилт, арчилгааны график

### БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭРИЙН НОГОО БАЙГУУЛАМЖИНД ХИЙГДЭХ НӨХӨН ТАРИЛТ, АРЧИЛГААНЫ АЖЛЫН ГРАФИК

2024

| № | Ногоон байгууламжийн | Ногоон байгууламжийн арчилгааны нарийвчилсан задаргаа | | Давтамж | Тоо хэмжээ | | 4 сар | | | 5 сар | | | 6 сар | | | 7 сар | | | 8 сар | | | 9 сар | | | 10 сар | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Арчилгаа | Нөхөн тарилт хэмжээ | эхний 10 хоног | дунд 10 хоног | адаг 10 хоног | эхний 10 хоног | дунд 10 хоног | адаг 10 хоног | эхний 10 хоног | дунд 10 хоног | адаг 10 хоног | эхний 10 хоног | дунд 10 хоног | адаг 10 хоног | эхний 10 хоног | дунд 10 хоног | адаг 10 хоног | эхний 10 хоног | дунд 10 хоног | адаг 10 хоног | эхний 10 хоног | дунд 10 хоног | адаг 10 хоног |
| | АЖИЛБАРЫН ТОО | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Мод,сөөг, зүлэг цэцэг шинээр | Мод бут сөөг | Хайлаас мод ургамалан хашлага | 1 | | 14у/м | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | Нарс | 1 | | 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | Голт бор шилжүүлэн суулгах | 1 | | 5у/м | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Зүлэг тарилт (м2) | | 1 | | 0 | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Цэцэг /м2/ | | 1 | | 0 | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Зүлэгт талбайн | Нарийн тармалт цэвэрлэгээ(м2) | | 2 | 6336.96 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Зүлэг хадалт, тайрч тэгшлэх(м2) | | 5 | 6336.96 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Мод, сөөг зүлэг | Шингэн бордоо хийх,гумин бусад (л) | | 1 | 71 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 5 | Мод сөөгөнд хэлбэржүүлэлт | Навчит модны хэлбэржүүлэлт хийх (бут) | | 3 | 11 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | Ургамалан хашлаганд хэлбэржүүлэлт хийх | | 3 | 64 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |

**Хавсралт №2- Гэрээт ажлын дэлгэрэнгүй задаргаа**

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын тайланг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн (2012.05.17) 7-р зүйлд заасны дагуу, Засгийн газрын 374-р тогтоолын 1-р хавсралт, БОНХСайдын 2014 оны 01-р сарын 06-ны өдрийн А-02 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 1. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлангийн агуулга

| № | Гүйцэтгэх ажил үүргүүд |
|---|---|
| 1 | **Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл:** Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбайн байршлын байгалийн бүс бүслүүр болон засаг захиргааны хуваариар тодруулж, алслалт, зам харилцааны онцлогийг тодорхойлно. Тухайн орчны физик газарзүйн үндсэн тодорхойлолтыг гаргаж, газарзүйн болон байгалийн бүс бүслүүрийн онцлог, ландшафт, газрын бүрхэвч, гадаргын тогтоц онцлогийг тодруулна. Төслийн талбайн газрын гадаргын эвдрэл, өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлж, үнэлсэн байна. Байршлын болон талбайн зургуудыг зохих масштабын дагуу гаргана |
| 2 | **Уур амьсгал:** Бүс нутгийн болон төсөл хэрэгжих орчны уур амьсгалын үндсэн нөхцөл, нарны гийгүүлэлт, цацраг, агаарын болон хөрсний гадаргын температур, агаарын чийг, хур тунадас, салхи, агаарын даралт зэрэг үзүүлэлтүүдийг түүний хэмжсэн тус бүрээр аль болох урт хугацааг хамруулсан мэдээллийг оруулна. Төслийн төлөвлөлтөд зайлшгүй авч үзэх, гамшиг үүсгэж болзошгүй цаг уурын үзүүлэлтүүдийг тодорхойлж, тусгана. |
| 3 | **Агаарын чанар:** Агаарын бохирдуулагч эх үүсвэрүүд, Агаарын чанарын ерөнхий төлөв байдал, агаар бохирдуулах хийн төлөвт бохирдуулах бодисууд, тоосонцорын агууламжийг түүнийг тодорхойлсон судалгааны арга зүйн хамт, мөн тухайн орчин дахь бохирдлын хяналт шинжилгээний станцууд, түүний хэмжилтийн талаарх мэдээллийг оруулж төслийн талбай, түүний орчим дахь агаар бохирдлын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлно. |
| 4 | **Геологийн тогтоц ба геоморфологи:** Бүс нутгийн болон төсөл хэрэгжих орчны геологийн тогтоц, геотектоникийн нөхцөл, газар хөдлөл, геоморфологийн нөхцөлийг тодруулан холбогдох зураг, схемийг хавсаргана. Төслийн талбай, түүний орчим дахь газрын хэвлийн эвдрэл, доройтол, бохирдлын өнөөгийн түвшинг тодорхойлно. |
| 5 | **Гадаргын ус:** Гадаргын усны сүлжээ, гадаргын усны урсац, нөөц, горим, чанар, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний орчмын томоохон гол мөрний талаарх нарийвчилсан мэдээлэл, гадаргын усны харуул станц, тэдгээрийн байршил, олон жилийн хэмжилтийн мэдээллийн хангамж, гидрологийн хээрийн судалгааны арга зүйг тодорхойлон бичиж оруулна. Төслийн талбай, түүний орчим дахь гадаргын усны ашиглалт, бохирдол, хомсдолын өнөөгийн түвшнийг тодорхойлж. Хээрийн хэмжилт, шинжилгээний дүнг эх хувиар, холбогдох фото болон бичлэгийг хавсаргана. |
| 6 | **Газрын доорх ус:** Төсөл хэрэгжих орчны болон төслийн талбайн гидрогеологийн нөхцөл, газрын доорх усны нөөц, горим, чанар, төслийн талбай дахь цооног, худаг, булгуудын мэдээлэл, газрын доорх усны хяналт, мониторингийн цэгүүдийн байршил, олон жилийн хэмжилтийн мэдээлэл, гидрогеологийн хээрийн судалгааны арга зүй зэргийг тодорхойлон бичиж оруулна. Төслийн талбай, түүний орчим дахь газрын доорх усны ашиглалт, бохирдол, хомсдолын өнөөгийн түвшнийг тодорхойлно. |
| 7 | **Хөрсөн бүрхэвч:** Төсөл хэрэгжих орчны болон төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэвшинж, зузаан, тархалт, морфологи шинж, ширхэглэгийн бүтэц, ялзмаг, ус-физик болон хими шинжийн үндсэн үзүүлэлтүүд, тэдгээрийг хээрийн болон суурин судалгааны явцад тодорхойлсон мэдээллүүдийг оруулна. Төслийн талбай дахь хөрсний эвдрэл, бохирдол, цөлжилтийн өнөөгийн түвшнийг тодорхойлж, хээрийн хэмжилт, дээжлэлт, шинжилгээний дүнг эх хувиар, холбогдох фото болон бичлэгийг хавсаргана. |

| № | Гүйцэтгэх ажил үүргүүд |
|---|---|
| 8 | **Ургамлан нөмрөг**: Төсөл хэрэгжих орчны болон төслийн талбайн ургамлан нөмрөгийн хэвшинж, зүйлийн бүрдэл, ангилал, нэн ховор болон ховор ургамлын төрөл, зүйлүүд, түүний тархалт, хамгааллын статус, төслийн талбай түүний орчмын ургамлан нөмрөгийн доройтол, бэлчээрийн талхлагдал, ургамлын биомасс, бүрхцийн үндсэн үзүүлэлтүүд, тэдгээрийг хээрийн болон суурин судалгааны явцад тодорхойлсон мэдээллүүдийг цуглуулна. Төслийн талбай дахь ургамлан нөмрөгийн доройтол, талхлагдалын өнөөгийн түвшнийг тодорхойлно. |
| 9 | **Амьтны аймаг:** Төсөл хэрэгжих орчны болон төслийн талбайд оршин амьдардаг, нутагладаг мөн дайран өнгөрдөг хөхтөн амьтад, шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид, загас шавжийн зүйлийн бүрдэл, амьдрах орчин, идэш тэжээлийн холбоо, ангилал, хамгааллын статус, тэдгээрийн амьдрах орчны талаар хээрийн болон суурин судалгааг хийж, үр дүнг боловсруулна. Зүйлийн бүрдлийн дэлгэрэнгүй жагсаалт, түүний тохиолдох магадлал, хоргодох дайжих, устах нөхцөлийн талаар тодорхойлох. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, төслийн талбай орчим дахь амьтдын хорогдол, үхэл, хууль бус агнуур, шилжилт хөдөлгөөний өнөөгийн түвшнийг тодорхойлж, үнэлгээ өгнө. |
| 10 | **Нийгэм, эдийн засаг:** Төслийн талбай, түүний орчимд амьдардаг төслийн шууд болон шууд бус нөлөөлөлд өртөх магадлалтай өрхүүд, түүний гишүүдийн бүртгэл, тэдний өнөөгийн амьжиргаа, хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшин, эзэмшил газар, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, ус хангамж, бэлчээр, тариалангийн талбай, мэдээлэл, нийтлэг үйлчилгээ (боловсрол, эмнэлэг, ахуйн үйлчилгээ, цахилгаан хангамж г.м)-ний хангамжийн түвшин зэргийг судалж, дүнг боловсруулна.<br>Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн харьяалагдах засаг захиргааны нэгж баг, сум дүүрэг, аймгийн хүн ам, нас хүйс болон хөдөлмөрийн нөөц, төсвийн орлого, зарлага, ажил эрхлэлт, дундаж орлого, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, дэд бүтцийн хөгжлийн өнөөгийн түвшин, худалдааны эргэлтийн хэмжээ зэрэг нийгмийн болон эдийн засгийн хөгжлийн түвшинг илтгэх бусад үзүүлэлтүүдийг тодорхойлно. |
| 11 | **Төслийн байгаль орчны болзошгүй нөлөөлөл:** Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт нөлөөлж болзошгүй хэлбэрүүд, түүний шинж чанар, нөлөөллийн цар хүрээ эрчмийг урьдчилсан байдлаар үнэлж тусгана. Мөн төслийн төлөвлөлтөд анхаарах байгалийн болон нийгмийн хүчин зүйлсийг тодорхойлж, байгаль орчин, нийгмийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авах арга хэмжээний чиглэлийг тодорхойлно. Мөн цаашид байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийхэд анхаарах асуудлууд, зарим зөвлөмжийг тусгана. |
| | |

Хүснэгт 2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн агуулга

| № | Гүйцэтгэх ажил үүргүүд |
|---|---|
| 1 | **Тайлангийн техникийн бус хураангуй**: Хураангуйд төслийн тодорхой бус асуудлууд, тэдгээрийн байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг онцлон тусгана. |
| 2 | **Төслийн тодорхойлолт:** Төслийн техник, эдийн засгийн үндэслэл (Feasibility Study Report), зураг төсөл (Design parameters and Layouts), бусад холбогдох баримт бичгүүдээс тухайн төслийн гол зорилт, цар хүрээ, хэмжээ, төсөл хэрэгжих үе шат, түүхий эд, байгалийн баялгийн ашиглалт, эрчим хүч, ус, дулааны хэрэгцээ,техник, технологийн сонголт, үйлдвэрлэлийн хүчин чадал, үйлдвэрлэлийн эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, гарах хаягдал, ялгарал, түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга зам зэргийг оруулна. |
| 3 | **Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ:** Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал, газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр гаргаж тусгана. Мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээ өгсөн дүнгүүдийг оруулна. |
| 4 | **Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж, бууруулах, арилгах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ**: Төслийг хэрэгжүүлэх явцад түүний дээр тодорхойлогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, нөлөөлөлд өртөх гадарга, хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндийн чиглэл бүрээр бууруулах арга хэмжээг тодорхойлсон дүнг тусгана. Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдэд анализ хийж урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах техник, технологи, удирдлага зохион байгуулалт, нөхөн сэргээх (уул уурхайн төслийн хувьд хаалтын үеийн зорилтууд), дүйцүүлэн хамгаалах чиглэлээр ангилж, түүний үр дүнг сайжруулах, уялдаа холбоог хангах, үр дүн, өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой зөвлөмжийг оруулна. ) |
| 5 | **Эрсдэлийн үнэлгээ, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө:** Төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй байгалийн аюул, гамшиг, үйлдвэрлэлийн осол, эрсдэлийн үнэлгээг холбогдох эрх бүхий байгууллагаас батлан мөрдүүлж байгаа аргачлалын дагуу хийж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж, Байгаль орчны 5 жилийн менежментийн төлөвлөгөөг боловсруулна. |
| 6 | **Гол үр дүнгүүд ба нэгдсэн дүгнэлт:** Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол үр дүн буюу тухайн төслийг хэрэгжүүлэх явцад төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, түүх соёлын үнэт зүйлсүүдэд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах, үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, төслийн хаалтын үеийн зорилтууд, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох, хяналт шинжилгээ хийх гол субъектууд, түүнийг илтгэх үзүүлэлтүүдийг нэгтгэн энэ хэсэгт тусгана. Мөн төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах, нутгийн иргэд оршин суугчдын эрх ашгийг хамгаалах талаар голчлон анхаарах асуудлууд, төслийг хэрхэн хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй байх талаар дүгнэлт, зөвлөмжийг боловсруулна. |

| | | |
|---|---|---|
| | **Төслийн нэр / Project name /** | **Premium Biulding Material llc** |
| | **Гүйцэтгэгчийн нэр / Company name /** | **Грийн Дрийм ХХК** |
| | **Нийт ажилласан хүний тоо** | **6** |
| | **Ажлын нэр, барилга:** | **Хаврын тармалт цэвэрлэгээ** |

**2024 оны 09 сарын 20 өдөр**











| | |
|---|---|
| **Төслийн нэр / Project name /** | **Premium Biulding Material llc** |
| **Гүйцэтгэгчийн нэр / Company name /** | **Грийн Дрийм ХХК** |
| **Нийт ажилласан хүний тоо** | **6** |
| **Ажлын нэр, барилга:** | **Ургамалан хашлага хэлбэржүүлэлт** |

**2024 оны 09 сарын 20 өдөр**














| | | |
|---|---|---|
| green dream LLC | **Төслийн нэр / Project name /** | **Premium Biulding Material llc** |
| | **Гүйцэтгэгчийн нэр / Company name /** | **Грийн Дрийм ХХК** |
| | **Нийт ажилласан хүний тоо** | **6** |
| | **Ажлын нэр, барилга:** | **Хог ургамалтай тэмцэх** |

**2023 оны 09 сарын 20 өдөр**






| | |
|---|---|
| **Төслийн нэр / Project name /** | **Premium Biulding Material llc** |
| **Гүйцэтгэгчийн нэр / Company name /** | **Грийн Дрийм ХХК** |
| **Нийт ажилласан хүний тоо** | **6** |
| **Ажлын нэр, барилга:** | **Зүлэг тайралт тэгшлэлт** |

**2023 оны 09 сарын 20 өдөр**








БАТЛАВ:
"ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС"
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

А.ГАНБОЛД

БАТЛАВ:
"ТАНСАГ ЛАНДШАФТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Х.ГАНГААМАА

**ТАРЬЦ, СУУЛГАЦ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2024 он 10 сарын 01-ний өдөр Дугаар 2024/ PBM-PD-2024/0107 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас **"ТАНСАГ ЛАНДШАФТ" ХХК /рд:5406684/**-ийг Ерөнхий инженер албан тушаалтай Э. Ариунбаяр төлөөлөн (***цаашид Худалдагч гэх***) нөгөө талаас **"ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС" ХХК /рд: 6266258/**-ийн Худалдан авалтын менежер албан тушаалтай З.Намуун төлөөлөн (***цаашид Худалдан авагч гэх***) нар харилцан тохиролцож хамтран ажиллахаар байгуулав.

## 1. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

1.1. Энэхүү гэрээнд заасны дагуу Худалдагч нь биет байдлын болон эрхийн доголдолгүй бараа бэлдэж Худалдан авагчид хүлээлгэн өгөх Худалдан авагч нь барааг хүлээн авч гэрээнд заасны дагуу төлбөрийг төлнө.
1.2. Барааны нэр, төрөл, тоо: **модны суулгац 105 ширхэг**
1.3. Барааны нийт үнэ: **5,000,000 /таван сая/ төгрөг**
1.4. Барааны үйлдвэрлэгч: Худалдагч тал өөрийн талбайд тарьж ургуулсан.
1.5. Барааны байршил: Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 34-р хорооны нутаг дэвсгэр дахь мод үржүүлэгийн талбай
1.6. Худалдагч бараанд холбогдох аливаа баримт бичгийг Худалдан авагчид барааг хүлээлгэн өгөхдөө шилжүүлнэ.

## 2. ЧАНАР

2.1. Худалдагчийн нийлүүлэх барааны чанар дараах шаардлагыг хангасан байна: (барааны чанарыг тодорхойлох улсын стандарт, техникийн нөхцөл, үйлдвэрлэгчийн гэрчилгээ, загвар гэх мэт)
2.2. Худалдагч барааны чанарыг "навчит модны суулгацын Техникийн шаардлага" стандарт / MNS 6141:2010 /, шилмүүст модны суулгацын Техникийн шаардлага" стандарт / MNS 6139:2010 /-аар тодорхойлно.
2.3. Худалдагч барааны аливаа дутагдал доголдол, гэмтлийг арилгана.

## 3. ХУГАЦАА, НӨХЦӨЛ

3.1. Худалдагч нь гэрээнд заасан барааг худалдан авагч талд 2024 оны 10 сарын 12-ны дотор нийлүүлнэ.
3.2. Худалдагч гэрээнд заасан нийлүүлэлтийн хугацаанаас өмнө барааг нийлүүлэх эрхтэй бөгөөд ингэх тохиолдолд Худалдан авагчид нийлүүлэлтийн тухай мэдэгдсэн байна. /Энд ийнхүү мэдээлэх тухай бусад шалтгааныг бичиж болно./
3.3. Модны суулгацыг худалдан авагч талд хүлээлгэн өгсөнөөс хойш гарах, суулгац учирсан механик гэмтэл /хугарах, мал амьтанд идэгдэх, гал түймэр үер ус, салхи, мөндөрт цохиулах гэх мэт байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас/, өвчин хортонд нэрвэгдэх, усалгаа арчилгаа дутагдах, зэрэг үхэл хоргодолд худалдагч тал хариуцлага хүлээхгүй.

## 4. ТӨЛБӨР ТООЦОО

4.1. Бараа дараах нэр төрөл, нэг бүрийн үнэтэй байна.

***Тэрбум мод төсөл намрын тарилт БЗД-ийн Олон улсын Эко цэцэрлэгт хүрээлэн***

| № | Ажил барааны нэр төрөл | хэмжээ | тоо | хэмжих нэгж | нэгж үнэ | нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гацуур | 1.5 | 5 | Ширхэг | 250,000 | 1,250,000 |
| 2 | Хус | 1.5 | 11 | Ширхэг | 60,000 | 660,000 |
| 3 | Агч | 0.8-1.5 | 36 | Ширхэг | 15,000 | 540,000 |
| 4 | Нарс | 1.5 | 3 | Ширхэг | 155,000 | 465,000 |
| 5 | Голтбор | 0.6-0.8 | 21 | Ширхэг | 25,000 | 525,000 |
| 6 | Тэхийн шээг | 0.5-0.8 | 7 | Ширхэг | 15,000 | 105,000 |
| 7 | Үхрийн нүд | 0.3-0.5 | 27 | Ширхэг | 15,000 | 405,000 |
| **Нийт мод сөөгний тоо** | | | **105** | | | **3,950,000** |
| 8 | Мод тарих | | 105 | Ширхэг | 10000 | 1,050,000 |
| **НИЙТ** | | | | | | **5,000,000** |

4.2. Гэрээгээр худалдах барааны нийт үнэ **5 000 000 /таван сая /** төгрөг болно.
4.3. Худалдан авагч нь Гэрээ байгуулж гарын үсэг зурж төлбөрийг **100%** урьдчилан шилжүүлнэ.
4.4. Төлбөр хийх данс: **ХААН БАНК дахь 5720676029 тоот** дансаар төлж барагдуулна.
4.5. НӨАТ энэхүү гэрээнд дурдсан үнэд ороогүй, И-баримт шивж өгнө.
4.6. Инфляци, зах зээлийн үнэ өсөх буурах болон валютын ханш өсөх, унах зэрэг нь энэхүү гэрээний нийт үнийг өөрчлөх үндэс болохгүй.

## 5. САВ БАГЛАА БООДОЛ

5.1. Худалдагч барааг аюулгүй сав баглаа боодолд хийж, Худалдан авагч барааг хүлээн авах хүртэл гэмтэл эвдрэл, устахаас сэргийлж баталгаажуулна.
5.2. Барааг нийлүүлэхээс өмнө Худалдан авагч тал сав баглаа боодол болон техникийн паспортыг Худалдагч талд хүлээлгэн өгч барааг бэлтгүүлэх үүрэг хүлээнэ.

## 6. АЧААЛАХ, ТЭЭВЭРЛЭХ

6.1. Ачаалах газар: Улаанбаатар хот БЗД
6.2. Худалдагч барааг 2024 оны 10 сарын 12-ны өдөр БЗД-ийн 28-р хороо ОЛОН УЛСЫН ЭКО ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД хүргэнэ.
6.3. Тээврийн хэрэгсэл, тээврийн зардлыг Худалдагч тал хариуцна.
6.4. Тээвэрлэх барааны овор хэмжээг Худалдагч тал Худалдан авагч талд урьдчилан тооцож мэдээлнэ.

## 7. БАРААГ ХҮЛЭЭН АВАХ

7.1. Худалдан авагч нь нийлүүлэгчийн аж ахуйн газараас барааг хүлээн авна.
7.2. Талууд хүлээн авах цэг дээр барааны тоо хэмжээ, чанарыг хуульд заасан арга ажиллагааны дагуу шалгана.
7.3. Талууд барааг хүлээлцэхдээ барааны тоо чанарын талаар маргаан гарч болзошгүй гэж үзвэл МҮХАҮТанхимын шинжээчдийг оролцуулан бараанд дүгнэлт гаргуулж болно.

## 8. ГЭРЭЭНИЙ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ

8.1. Гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
8.2. Энэхүү гэрээ нь модны суулгац нийлүүлэх үүргийг бүрэн гүйцэтгэж, 2024 оны 10 сарын 12-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

## 9. ТАЛУУДЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

9.1. Гэрээг зөрчсөн тал нөгөө талдаа олох байсан орлогыг оролцуулан бүх холбогдох хохирлыг хуулийн дагуу төлнө.

9.2. Хэрэв аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ гэрээний хүчин төгөлдөр хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлэхээс татгалзвал, нөгөө тал нэмж торгууль нэхэмжлэх эрхтэй.

9.3. Энэхүү гэрээний бусад нөхцлийг зөрчсөн тал санхүүгийн хариуцлага хүлээнэ.

## 10. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

10.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

10.2 Дээрхи давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 11. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

11.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 12. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ

12.1. Энэхүү гэрээний нөхцлийг талуудын хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан баримт бичгийн дагуу өөрчилж, нэмж болно.

12.2. Талууд нөгөө талын бичгэн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй.

## 13. БУСАД НӨХЦӨЛ

13.1. Энэхүү гэрээ хоёр хувь үйлдэгдэх бөгөөд талуудад нэг нэг хувь хадгалагдана.

13.2. Монгол Улсын Иргэний хуулиар энэхүү гэрээнд дурдаагүй асуудлыг зохицуулна. /Энд өөр хууль тогтоомжийн актыг дурдаж болно/

13.3. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээний өмнөх хэлэлцээр, харилцаа холбоо, зөвлөмж, санал хүчингүй болно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Худалдагч: | Худалдан авагч: |
| --- | --- |
| “ТАНСАГ ЛАНДШАФТ” ХХК-ны<br>Ерөнхий инженер: Э.АРИУНБАЯР | “ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС” ХХК-ийн<br>Худалдан авалтын менежер: З.НАМУУН |
| Гарын үсэг: | Гарын үсэг: |
| Тамга: | Тамга: |
| Утасны дугаар: 88083841 | Утасны дугаар: 91119235 |

Гэрээ байгуулсан: 2024 оны 10 сарын 01-ний өдөр

ТЭРБУМ МОД
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

IGM
INTERNATIONAL GARDEN OF MONGOLIA

# БАТЛАМЖ

Премиум бьюлдинг материалс ТАНАА

«Арчлахгүй бол ургахгүй» уриан дор намрын бүх нийтийн мод тарилтын өдөр «Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн»-ийн талбайд мод тарьж бидний үйл ажиллагааг дэмжин оролцож ногоон ирээдүйг бүтээсэн танай хамт олонд талархал илэрхийлье.

«Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн» ОНӨҮГ-ын

ЗАХИРАЛ ______ Б.Сайнжаргал

УЛААНБААТАР ХОТ
ОЛОН УЛСЫН ЭКО ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН АТҮГ
9022010594 6809898 АМТ06247

Төслийн танилцуулга видеог эндээс үзнэ үү

2024 ОН

## Тансаг ландшафт ХХК үнийн санал

***"ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС" ХХК Тэрбум мод төсөл намрын тарилт БЗД-ийн Олон улсын Эко цэцэрлэгт хүрээлэн***

| № | Ажил барааны нэр төрөл | хэмжээ | тоо | хэмжих нэгж | нэгж үнэ | нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гацуур | 1.5 | 5 | Ширхэг | 250000 | 1250000 |
| 1 | Хус | 1.5 | 11 | Ширхэг | 60000 | 660000 |
| 2 | Агч | 0.8-1.5 | 36 | Ширхэг | 15000 | 540000 |
| 3 | Нарс | 1.5 | 3 | Ширхэг | 155000 | 465000 |
| 4 | Голтбор | 0.6-0.8 | 21 | Ширхэг | 25000 | 525000 |
| 5 | Тэхийн шээг | 0.5-0.8 | 7 | Ширхэг | 15000 | 105000 |
| 6 | Үхрийн нүд | 0.3-0.5 | 27 | Ширхэг | 15000 | 405000 |
| Нийт мод сөөгний тоо | | | 105 | | | 3950000 |
| 11 | Мод тарих | | 105 | Ширхэг | 10000 | 1050000 |
| нийт | | | | | | 5000000 |

Холбоо барих: 88083841, 88081348

цахим хаяг: Tansaglandscape@gmail.com

**ГЭРЭЭНИЙ ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН ХУУДАС**

ЗАРЛАГЫН ГЭРЭЭ

Компанийн нэр: PBM-PD-2024|0071
Гэрээний төрөл: Ажил гүйцэтгэх гэрээ

| | | |
|---|---|---|
| Гэрээний хураангуй | | ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ |
| **1. ГЭРЭЭЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ** | | |
| | Нэр: | Элемент ХХК |
| | Регистрийн дугаар: | 2100061 |
| | Хаяг: | Улаанбаатар Налайх 3-р хороо Хүчил төрөгчийн гудамж |
| | Утас: | 86103790 |
| | Данс: | Голомт банк \| 1715164140 \| Төгрөг<br>ХААН БАНК \| 5007200166 \| Төгрөг<br>ХААН БАНК \| 5779170822 \| Төгрөг |
| | НӨАТ төлөгч эсэх : | Үгүй |
| **2.ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ** | | |
| | Гэрээний нэр: | Ажил гүйцэтгэх гэрээ-Стандарт |
| | Гэрээний зүйл: | |
| | Гэрээний хугацаа: | Эхлэх хугацаа: 2024-06-20 Дуусах огноо : 2025-06-20 |
| | Автоматаар сунгагдах эсэх: | Үгүй |
| | Гэрээний чиглэл: | |
| **3. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ** | | |
| | Төлбөрийн давтамж: | Гүйцэтгэлээс хамааран |
| | Нийт төлбөр: | 3,000,000.00 (MNT) |
| | Төлбөрийн хэлбэр: | Бэлэн бус |
| | Татварын мэдээлэл: | |
| | Төсөвтэй эсэх: | Тийм |
| | Төсвөөс хэтэрсэн эсэх: | Үгүй |
| | Төлбөр төлөх хуваарь: | Төрөл / Хувь / Дүн / Валют<br>Нийт гэрээний төлбөр / 100.00 / 3,000,000.00 / MNT |
| | Алданги, торгууль: | Үндэслэл / Хувь |
| **4. БУСАД** | | |
| | Нэмэлт гэрээ эсэх: | Байхгүй - |
| | Өөрчлөгдсөн нөхцөл: | |
| | Нэмэлт тайлбар: | |
| | Өмнө гэрээ байгуулж байсан эсэх | Үгүй |
| **5. ХЯНАЛТЫН САМБАР** | | |
| | Гэрээний менежер | Э.Уянга/Худалдан авалтын ажилтан/ 2024-07-03 10:47:06 |
| | Худалдан авалтын удирдлага | З.Намуун/Худалдан авалтын менежер/ 2024-07-03<br>ok |
| | Худалдан авалтын захирал | П.Мөнхнасан/Managing Director/ 2024-07-09<br>саналгүй. |

БАТЛАВ:
“ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

А.ТАНБОЛД

БАТЛАВ:
“ЭЛЕМЕНТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ЭНХБАДРАЛ

**ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

PBM-PD-2024/0071

2024 оны 6-р сарын 20-ны өдөр № ХБ-24/102 Улаанбаатар хот

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Нэг талаас “Элемент” ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/-ийг төлөөлж, Химийн мэргэжилтэн албан тушаалтай Э.Халиун, нөгөө талаас /цаашид захиалагч гэх/-ыг “Премиум Бьюлдинг Материалс” ХХК-ийг төлөөлж Худалдан авалтын менежер албан тушаалтай З.Намуун, бид харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 5 сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 тоот тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь зориулалтын шатаах зууханд химийн хорт болон аюултай хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх, устгахад оршино.

1.2. Захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

1.3. Энэхүү гэрээ 1 (нэг) жил буюу 2024 оны 6 сарын 20-ны өдрөөс 2025 оны 6-р сарын 20-ны өдөр хүртэлх хугацаагаар байгуулав.

1.4. Талууд гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах үйл ажиллагааны ерөнхий зарчмаар ажиллана. Үүнд:

1.4.1. Захиалагч нь аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, устгах захиалгыг гүйцэтгэгчийн дараах холбогдох хаягаар өгнө: (8626-0060, 8009-3790)

1.4.2. Гүйцэтгэгч нь захиалгыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор аюултай хог хаягдлыг захиалагчийн өгсөн захиалга, тоо хэмжээ, байршилд үндэслэн тээвэрлэх хуваарь гарган захиалагчид мэдэгдэнэ.

1.4.3. Хуваарьт хугацаанд гүйцэтгэгч заагдсан байршлаас хог хаягдлыг ачиж, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Талууд аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах бөгөөд тал тус бүр 1 хувийг хадгална.

1.4.4. Дээр 1.4.3-т зааснаар хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд Талууд гарын үсэг зурснаар тухайн хог хаягдал гүйцэтгэгчийн эзэмшилд бүрэн шилжсэнд тооцогдох ба хуульд заасны дагуу тээвэрлэн, устгах үүрэг болон бусад эрсдэл гүйцэтгэгчид шилжинэ.

1.4.5. Гүйцэтгэгч нь хог хаягдлыг усгалд оруулсны дараа устгалын актыг захиалагчид ирүүлэх бөгөөд уг актад үндэслэн төлбөр тооцоог гэрээнд заасан нөхцөлөөр төлнө.

## ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Захиалагч дараах эрхтэй:

2.1.1. Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,

2.1.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах,

2.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.

2.2. Захиалагч дараах үүрэгтэй:

2.2.1. Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх,

2.2.2. Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах,

2.2.3. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх. Мөн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл дагалдан өгч явуулах,

2.2.4. Аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах,

2.2.5. Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих,

2.2.6. Аюултай хог хаягдал тээвэрлэж, устгасан хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх,

2.2.7. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах бодит хохирлын хувьд захиалагч бүрэн хариуцлага хүлээх,

2.2.8. Аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтныг байгууллага дээрээ байлгаж, хог ачилтад хяналт тавих тус тус үүрэгтэй.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч дараах эрхтэй:

3.1.1. Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй;

3.1.2. Аюултай хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй;

3.1.3. Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шошготой, аюултай тэмдэглэгээтэй байхыг шаардах хаяггүй бол тээвэрлэхгүй байх эрхтэй;

3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичиггүй бол хог хаягдлыг тээвэрлэхгүй байх эрхтэй.

3.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

3.2.1. Аюултай хог хаягдлыг захиалагчийн өгсөн захиалга, тоо хэмжээ, байршилд тулгуурлан тээвэрлэх хуваарь гарган захиалагчид мэдээлэл өгч зориулалтын тээврийн хэрэгслээр саадгүй тээвэрлэх,

3.2.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн

аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах,

3.2.3. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохирлыг гүйцэтгэгч бүрэн хариуцах,

3.2.4. Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх,

3.2.5. Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах,

3.2.6. Устгал хийгдсэний дараа устгалын акт гаргах тус тус үүрэгтэй,

3.2.7. Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.

## ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

4.1. Үйлчилгээний төлбөр нь тухайн устгах аргачлалын дагуу устгалын үед аюултай хог хаягдлын хэмжээнээс хамааран, устгал өгөх бүрд тооцож нэхэмжилнэ. Аюултай хог хаягдлын устгалын төлбөрийг хавсралт №1-т тусгав.

4.2. Захиалагч аюултай хог хаягдал устгах гэрээ байгуулахдаа гэрээний баталгаа болгож **500,000.0 /Таван зуун мянга/** төгрөгийг 4.5 дахь заалтад заасан гүйцэтгэгчийн дансанд байршуулна. Уг төлбөр нь урьдчилгаа төлбөрт тооцогдох бөгөөд гэрээний хүчинтэй хугацаанд хийгдсэн устгалын зардлаас хасагдаж тооцогдоно.

4.3. Аюултай хог хаягдлыг гүйцэтгэгч ачилт тээвэрлэлт хийх үед болон устгалын төвд хүлээн аван нарийн хэмжилт хийж гүйцэтгэлээр захиалагч талаас нэхэмжилнэ.

4.4. Нэг (1) удаагийн тээвэрлэлтийн үнэ хаягдлын хэмжээнээс хамаарч өөр өөр байна. Хэрэв гэрээний хавсралт №1-т заасан тээвэрлэлтийн хэмжээ буюу 1 рейс нь 1 тонн)-нээс дээш тохиолдолд тээвэрлэлтийн төлбөрийг тохиролцоно.

4.5. Гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэж дууссаны дараа гэрээнд заасан журмаар устгалын акт үйлдсэж нэхэмжлэхийн хамт захиалагчид илгээснээс хойш ажлын 5 хоногийн дотор "Элемент" ХХК-ийн 1715164140 /Голомт банк/ тоот дансанд төлнө.

4.6. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаандаа төлбөр төлөгдөөгүй тохиолдолд боломжит хугацааг мэдэгдэж, онцгой объектыг харгалзан үзэж, энэхүү хугацаанд төлбөр төлөх хүртэл үйлчилгээг тасалдуулахгүй хүргэнэ.

4.7. Төлбөр тооцоог байгууллагын данснаас бусад хувь хүний дансанд шилжүүлснээс үүдэх хохирлыг гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.

## ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1 Энэхүү гэрээний 4.4-т заасан хугацаанд захиалагч тал үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувиар алданги төлнө.

5.2 Энэхүү гэрээний 4.7-д заасан хугацаанд гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувиар алданги төлнө.

5.3 Үйл ажиллагаандаа дагаж мөрдөх дүрэм журмыг мөрдөөгүйгээс гэрээнд оролцогч талуудад гэм хор учирсан бол буруутай тал нь хариуцлагыг бүрэн хүлээнэ.

5.4 Талууд учирч болзошгүй хохирол, үйл ажиллагааны саадыг бие биедээ мэдэгдэх, анхааруулах, асуудлыг зөвшилцөх замаар шийдвэрлэж байна.

5.5 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.6 Химийн хорт болон аюултай хог хаягдлын эзэмшил гэрээний 1.4.4-т заасны дагуу шилжсэнээс хойш гарч болох аливаа эрсдэлийг гүйцэтгэгч хариуцах бөгөөд түүнээс сэргийлсэн холбогдох арга хэмжээг урьдчилан авч ажиллана.

## ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.

6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно.

6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тухай тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ тохиолдолд Талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй,эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тал нь энэ тухайгаа нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

## ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

7.1. Талууд энэ гэрээг биелүүлэх явцад иргэний болон эрх зүйн маргаанд хамаарагдах асуудлаар бие биедээ өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч ажиллана.

7.2. Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл захиалагчийн оршин байгаа газрын харьяаллаар Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## НАЙМ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

8.1. Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, ажилтан ажиллагсад, харилцагч, үйлчлүүлэгчийн байгууллагын болон ажилтны хувийн нууцад хамааралтай (техник, санхүү, бизнес, хувь хүний эрүүл мэндийн мэдээллийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

8.2. Энэхүү гэрээний 8.1-д заасан нөхцөлийг зөрчсөн тал үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үр дагавар, хохирлыг хуулийн дагуу арилгах үүрэг хүлээнэ.

## ЕС. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

9.1. Талууд харилцан тохиролцсоноор гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах тохиолдолд нөгөө талдаа хуанлийн 15-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэлд гэрээг цуцлах үндэслэл, цуцлах огноог тодорхой дурдсан байна.

9.2. Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:

9.2.1. Гэрээний хугацаа дуусаж, гэрээний биелэлтийг дүгнэснээр,

9.2.2. Талууд харилцан тохиролцсоноор,

9.3. Аль нэг талын дараах буруутай үйлдэл, эс үйлдэхүй, үүргийн зөрчлийн улмаас Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болох бөгөөд буруутай тал нь нөгөө талдаа учирсан бодит хохирлыг үл маргах журмаар нөхөн төлөх үүрэгтэй.Үүнд:

9.3.1. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа (2 ба түүнээс дээш удаа) биелүүлээгүй бөгөөд энэ талаар нөгөө талд бичгээр мэдэгдэл шаардлага хүргүүлсэн боловч биелүүлээгүй,

9.3.2. Талууд оролцогч талын нэр хүндэд ноцтой хохирол учруулсан зэрэг болно.

## АРАВ. ГЭРЭЭНИЙ БАТАЛГАА

10.1. Энэхүү гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

10.2. Талууд харилцан тохиролцвол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

10.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, хүсэлтийг бичгээр үйлдэж 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар, баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлнэ.

10.4. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусах хүртэл хүчинтэй үйлчилнэ.

10.5. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

10.6. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн туршлагатай ажилтан, зориулалтын тээврийн хэрэгсэлтэй, ажил гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн холбогдох хууль журмын дагуу шударгаар авсан бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй болохыг үгээр баталж байна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Химийн мэргэжилтэн албан тушаалтай

............................................/Э.Халиун/

Утас:89244020

Ерөнхий нягтлан бодогч албан тушаалтай

............................/А.Энхтуяа /

Утас:86113790

*/Тамга, тэмдэг/*

Харилцах утас: 8610-3790, 9910-7745

РД:2100061

Хаяг: Налайх дүүрэг 3-р хороо, Бүс нуур /12610/

Захиалагчийг төлөөлж:

Худалдан авалтын албан тушаалтай

............................................ /З.Намуун/

Утас: 91119235

РД: 6266258

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19/А, Шангри-Ла Оффис Центр, 23-р давхар

Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх ХБ-24/02 дугаартай гэрээний хавсралт №1

Энэхүү гэрээгээр зөвхөн доорх хаягдлыг хүлээн авч хадгалан, устгал хийнэ.

| АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЭЛ | | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгж үнэ/төгрөг |
|---|---|---|---|---|
| 1 | Зэвээр бохирдсон түлш | л | 1 | 1,500.0 |
| 2 | Хөдөлгүүрийн тос | л | 1 | 2,000.0 |
| 3 | Товуд | л | 1 | 2,000.0 |
| 4 | Баттерэй | кг | 1 | 10,600.0 |
| 5 | Акумлятор | кг | 1 | 7,000.0 |
| 6 | Тосол | л | 1 | 2,000.0 |
| 7 | Тээвэрлэлт /хот дотор 1тн хүртэлх/ | рейс | 1 | 350,000.0 |

/Дээрх тээвэрлэлт, устгалын зардал нь НӨАТ ороогүй дүн бөгөөд зардлыг тооцохдоо НӨАТ -ын 10% нэмэгдэж бодогдоно./

**Устгах арга аргачлал:** Дээрх хог хаягдлыг зориулалтын эргэлтэт системтэй 2ST загварын шатаах зууханд 2 давхар шатаах камер (1-р камер $800^0$C, 2-р камер $1200^0$C)-т 99% шатааж устгалд оруулна. Шатаалтаас үүссэн үнсний хаягдлыг зориулалтын ландфиллын талбайд булшилж устгана.

Гэрээний үнийн задаргааг гаргасан:
Гүйцэтгэгч талаас:
Химийн мэргэжилтэн албан тушаалтай Халиун Э.Халиун

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЕМЕНТ
ХХК
1117250399
2100061 СЕТ1561

хавсралт
НХ Маягт Т-1

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын
5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

## НЭХЭМЖЛЭХ № 24/ 2019

Нэхэмжлэгч:
Байгууллагын нэр:
**"ЭЛЕМЕНТ" ХХК**
**РД: 2100061**
**Хаяг: Налайх дүүрэг**
**3-р хороо**
Утас, факс: 8610-3790
Э-шуудан:…………………………

Хариуцагч:
Байгууллагын нэр:
**"Премиум Бьюлдинг Материалс" ХХК**
**РД:** ...6266258..................
**Хаяг: УБ хот**
Утас, факс: .........................................
Гэрээний № ...................................
Хаяг: ................................................

**Банкны нэр: Хаан Банк**

Нэхэмжилсэн огноо: 2024.10.28
Төлбөр төлөгдөх хугацаа 2024.11.05

**Банкны дансны дугаар: 5007200166**

| № | Гүйлгээний утга | Тоо хэмжээ /л/ | Нэгжийн үнэ /₮/ | Нийт үнэ /₮/ |
|---|---|---|---|---|
| 1 | ХБ 24/207 тоот акт хаягдал масло | 250 | 2,000 | 500,000 |
| 2 | Хаягдал тулш устгалын төлбөр | 850 | 1,500 | 1,275,000 |
| 3 | Тээвэрлэлтийн зардал /1 удаа/ | 1 | 350,000 | 350,000 |
| | | | | - |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | Дүн | 2,125,000 |
| | | | НӨАТ | 212,500 |
| | | | урьдчилгаа | (500,000) |
| | | | Нийт дүн | 1,837,500 |

**Мөнгөн дүн: /үсгээр/**

Нэг сая найман зуун гучин долоон мянга таван зуун төгрөг

Нягтлан бодогч: ............................/Н.Пүрэвсүрэн/

Тамга:

"ЭЛЕМЕНТ" ХХК
САНХҮҮ
СБТ-1561
УЛААНБААТАР ХОТ

Хүлээн авсан: ........................ ............/........................../

Утас :

хавсралт
НХ Маягт Т-1

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын
5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

## НЭХЭМЖЛЭХ № 24/ 2019

Нэхэмжлэгч:
Байгууллагын нэр:
**"ЭЛЕМЕНТ" ХХК**
**РД: 2100061**
**Хаяг: Налайх дүүрэг**
**3-р хороо**
Утас, факс: 8610-3790
Э-шуудан:…………………………

Хариуцагч:
Байгууллагын нэр:
**"Премиум Бьюлдинг Материалс" ХХК**
**РД: ......................................**
**Хаяг: УБ хот**
Утас, факс: .........................................
Гэрээний № ...................................
Хаяг: ................................................

**Банкны нэр: Хаан Банк**

Нэхэмжилсэн огноо: 2024.10.28
Төлбөр төлөгдөх хугацаа 2024.11.05

**Банкны дансны дугаар: 5007200166**

| № | Гүйлгээний утга | Тоо хэмжээ /л/ | Нэгжийн үнэ /₮/ | Нийт үнэ /₮/ |
|---|---|---|---|---|
| 1 | ХБ 24/207 тоот акт хаягдал масло | 250 | 2,000 | 500,000 |
| 2 | Хаягдал тулш устгалын төлбөр | 850 | 1,500 | 1,275,000 |
| 3 | Тээвэрлэлтийн зардал /1 удаа/ | 1 | 350,000 | 350,000 |
| | | | | - |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | Дүн | 2,125,000 |
| | | | НӨАТ | 212,500 |
| | | | урьдчилгаа | (500,000) |
| | | | Нийт дүн | 1,837,500 |

**Мөнгөн дүн: /үсгээр/**

Нэг сая найман зуун гучин долоон мянга таван зуун төгрөг

Нягтлан бодогч: ............................/Н.Пүрэвсүрэн/

Тамга:

САНХҮҮ
2100061
СБТ-1561
УЛААНБААТАР ХОТ

Хүлээн авсан: ........................ ............/........................../

Утас :

Scanned with CamScanner

# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАЛЫН АКТ

ELEMENT LLC

Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, шатаах, устгах төвлөрсөн байгууламж

Хаяг: НД, 3-р хороо Бүс нуур 12610 гудамж 77 тоот    Утас: 7707-3790, 7717-3131

2024 оны 10 сарын 29 өдөр    Актын дугаар: 24/107    Улаанбаатар хот

Аюултай хог хаягдал үүсгэгч: **Премиум бьюлдинг материалс ХХК**

*Устгалд оруулсан аюултай хог хаягдлын жагсаалт*

| № | Хаягдлын нэр, төрөл | Хэмжээ | Нэгж кг | Аюулын ангилал |
|---|---|---|---|---|
| 1 | Масло | 250.0 | кг | Шатамхай |
| 2 | Хаягдал түлш | 850.0 | кг | Шатамхай |
| Нийт | | 1100.0 | - | |

**Устгасан аргачлал:**

Дээрхи **1100.0** кг шатамхай хог хаягдлыг хаягдлыг "Элемент" ХХК-ийн аюултай хог хаягдал хүлээн авах, устгах комисс хүлээн авч зориулалтын шатаах зууханд 1200℃ -т бүрэн шатааж хаягдал үнсийг ландфиллдэж устгав.

**Жич:** Устгалд орсон бодисын нэр төрлийн жагсаалт хавсаргав.

**Устгал хийсэн**

Химийн мэргэжилтэн [signature] [stamp: ЭЛЕМЕНТ ХХК УСТГАЛД ОРУУЛАВ] /Э.Халиун/

**Акт хүлээн авсан**

.................................... /....................................../

Scanned with CamScanner

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/21 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

**Дагалдах бичгийн дугаар:**

**1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл**

Бүртгэлийн дугаар: Ү [ ][ ][ ][ ][ ]

**2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:**

**Овог нэр (дармал үсгээр бичих)**: Баткуу Санчир

Гарын үсэг (тамга): [signature]

2024 он 10 сар 22 өдөр

**3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:**

**1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар:** 37-84

**Тээвэрлэгч аж ахуй нэгжийн нэр:** "Элемент" ХХК

**4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:**

| № | Аюултай хог хаягдлын нэр | Аюулын ангилал | Савалгаа ны | Савны | | Хэмжээ | Нэгж (кг, л) | Аюултай хог хаягдлын код | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дугаар | төрөл | | | | | | | | | |
| 1 | Масло | | | | | 950л | | | | | | | | |
| 2 | [illegible] | | | | | 850л | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | | | | | | |
| 9 | | | | | | | | | | | | | | |
| 10 | | | | | | | | | | | | | | |

**5. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:**

______________________________

______________________________

**6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч:**

**1/ Овог нэр (дармал үсгээр бичих)**: [signature]

Гарын үсэг (тамга): ЭЛЕМЕНТ ХХК ТЭЭВЭРЛЭВ [signature]

2024 он 10 сар 22 өдөр

**7. Үл зохицол:**

______________________________

______________________________

**8. Аюултай хог хаягдал хүлээн авагчийн мэдээлэл:**

Аж ахуй нэгжийн нэр: **Элемент ХХК**  Бүртгэлийн дугаар: **0 0 0 0 1 1**

Аюултай хог хаягдал хүлээн авсан:

**Овог нэр (дармал үсгээр бичих)**: [signature]

Гарын үсэг (тамга): ЭМ. ХИМИЙН БОДИС ХАДГАЛАВ "ЭЛЕМЕНТ" ХХК [signature]

он сар өдөр

Scanned with CamScanner

Хэвлэсэн: 2024-10-30 13:31:28

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

# ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 5007200166 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Элемент ХХК |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХААН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 1,837,500.00 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с химийн хог хаягдлын төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-10-30 | |

## ХОГ ХАЯГДАЛ ХАЯХ ГЭРЭЭ

PBM-PD-2024/0089

2024 оны 07 дугаар сарын 26 №24/107 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ /цаашид "А" гэх/ түүнийг төлөөлж газрын дарга Б.Мөнхцэцэг, нөгөө "Премиум Бьюлдинг Материалс" ХХК РД: 6266258 /цаашид "Б" гэх/ түүнийг төлөөлж Худалдан авалтын менежер З.Намуун /хамтад нь "талууд" гэх/ нар Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2023 оны 50-р тогтоол, Хот тохижилтын газрын 2016 оны дүрэм, 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолоор батлагдсан Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам зэргийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

### Нэг. Үндсэн нөхцөл

1.1.Б тал нь өөрийн байгууллагын талбайгаас үүсэх ахуйн хог болон барилгын хаягдлыг **63-94 УНТ, 72-90 УНИ, 73-80 УНИ, 04-87 УНТ, 19-45УНП, 41-85 УНТ, 88-91 УББ, 88-92 УБД, 03-71 УАК, 02-49НАА, 82-22УБР** улсын дугаар бүхий автомашинуудаар тээвэрлэн Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдэд байрлалтай төвлөрсөн хогийн цэгүүдэд хаях хог хаягдлыг А талын пүүнд хэмжилт хийж, баримт үйлдсэнд үндэслэн ландфиллийн ажлын хөлсийг Б тал нь гэрээнд заасан хугацаанд нь төлөх санхүүгийн харилцааг зохицуулна.

### Хоёр. Төлбөр, тооцоо хийх журам

2.1.Нэг тонн хог хаягдлын үнэлгээ: **4350** */дөрвөн мянга гурван зуун тавь/* төгрөг байна. НӨАТ шингэсэн үнэ болно.

2.2.Зориулалтын цэгт хог хаягдал хаях үеийн нийт тонн, хэмжээний төлбөрийг сар бүрийн 30-ны өдрөөр тооцоо нийлж, А талын **Хаан банкны 5064975024** тоот дансанд нэхэмжлэхийн дагуу шилжүүлнэ.

2.3."Хог хаягдлын тухай" хууль, бусад эрх зүйн актын өөрчлөлт, зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч А талын үнэ тарифт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

### Гурав. Гэрээний үйлчлэх хугацаа

3.1.Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоов.

3.2.Гэрээ үйлчилж эхлэх хугацаа: 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдөр байна.

3.3.Гэрээний дуусах хугацаа: 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл байна.

**Дөрөв. Талуудын эрх, үүрэг**

4.1.Б тал нь хог хаягдлыг зориулалтын машинаар ачиж, тээвэрлэх

4.2.Б тал нь хог хаягдал тээвэрлүүлсэн төлбөрөө энэ гэрээний 2.2-т заасны дагуу хугацаанд нь бүрэн төлнө.

4.3.Б тал нь төлбөр төлөх үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцон тээвэрлэгч талд алданги төлнө. Нийт алдангийн хэмжээ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

4.4.Б тал нь тухайн хогийн цэгт ажиллаж буй А талын ажилчин, ажилтан нарын зааврын дагуу хог хаягдлаа буулгана.

4.5.Б тал нь Тэсэрч дэлбэрэх аюултай хог хаягдал болон галтай хог хаягдал ачуулахгүй байх үүрэгтэй.

4.6.Б тал нь хогийн цэгийн пүү ажиллуулж буй А талын ажилтнаас пүүгийн баримтаа авах бөгөөд тооцоо нийлэх үед баримт болох

4.7.Б тал нь Тээврийн хэрэгсэл, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.

4.8.Талууд өөр өөрсдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилга, холбогдох журмыг чанд мөрдөн ажиллана.

4.9.А тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө нэхэмжлэх, шаардан авах эрхтэй.

4.10.Б талын хог хаягдал нь Хог хаягдлын тухай хуульд заасанчлан аюултай хог хаягдал байгаа тохиолдолд тухайн хог хаягдлыг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

4.11.Б тал нь А талын чиглүүлэгчийн заасан газраас өөр газарт дур мэдэн хог хаягдлаа буулгасан тохиолдолд 250 000 /хоёр зуун тавин мянган/ төгрөг хүртэл төгрөгөөр торгоно.

4.12.Б талын хог хаягдал нь мал, малын гаралтай хог хаягдал, аюултай хог хаягдал байсан тохиолдолд дараа нь учирч болзошгүй асуудалд Б тал нь бүрэн хариуцлага хүлээнэ.

**Тав. Талуудын хүлээх хариуцлага**

5.1.Талууд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, энэхүү гэрээг сахин биелүүлж ажиллана.

5.2.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

**Зургаа. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам**

6.1.Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол харилцан зөвшилцсөний үндсэн дээр нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэн эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.

6.2.Гэрээний хугацааг сунгах болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа аль нэг тал энэ гэрээний хугацаа дуусахаас нэгээс доошгүй өдрийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэх ба уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор нөгөө тал хариу мэдэгдэнэ.

6.3.Гэрээний сунгалт, нэмэлт өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

**Долоо. Гэрээ цуцлах журам**

7.1.Талууд харилцан тохиролцсоноор гэрээг цуцалж болно.

7.2.Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачилгаар гэрээг цуцалж болно.

7.3.Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

7.4.Хэрэв аль нэг тал гэрээг цуцлах саналтай бол нөгөө талдаа 1 сарын өмнө албан бичгээр мэдэгдэж, гэрээ цуцалсан тухай акт үйлдэн үйлчилгээ, төлбөр тооцоог дуусгавар болгоно.

**Найм. Давагдашгүй хүчин зүйл**

8.1.Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.

8.2.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

8.3.Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

**Ес. Маргаан шийдвэрлэх**

9.1.Энэхүү гэрээнд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

9.2.Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад талуудын хооронд гарах аливаа асуудлыг албан бичгээр мэдэгдэнэ.

9.3.Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар үүссэн маргааныг гэрээний үндсэн нөхцөл, агуулгад нийцүүлж талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх ба зөвшилцөөнд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Арван. Бусад заалт**

10.1.Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болсноор гэрээ дуусгавар болно.

10.2.Гэрээг шинэчлэх, сунгах асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

10.3.Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг, нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

10.4.Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| **А талыг төлөөлж** | **Б талыг төлөөлж** |
| --- | --- |
| “ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА<br><br>Б.МӨНХЦЭЦЭГ | “ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС” ХХК -ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br><br>А.ГАНБОЛД |
| САНХҮҮ БҮРТГЭЛ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ<br><br>М.ОЮУНСҮРЭН | “ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС” ХХК -ИЙН ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕР<br><br>З.НАМУУН |
| САНХҮҮ БҮРТГЭЛ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ТООЦООНЫ НЯГТЛАН БОДОГЧ<br><br>Ж.ДААРИЙМАА | |
| Хаяг: Баянзүрх дүүргийн 1 хороо, Залуучуудын гудамж, Сансар тунель дээрх өөрийн байр<br><br>Утас: 11- 453501 | Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19/А, Шангри-Ла Оффис Центр, 23-р давхар<br><br>Утас: 91119235, 88108320 |

Хэвлэсэн: 2024-10-29 13:16:28

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

# ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 5064975024 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Хот тохижилтын газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХААН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 6,291,231.00 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с Хог хаягдлын төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-10-04 | |

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

# ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 5064975024 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Хот тохижилтын газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХААН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 5,330,055.00 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с хогны төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-09-11 | |

Хэвлэсэн: 2024-10-29 13:16:09

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 5064975024 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Хот тохижилтын газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХААН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 10,689,255.00 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с хог хаягдлын төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-08-30 | |

Хэвлэсэн: 2024-10-29 13:15:58

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

# ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 5064975024 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Хот тохижилтын газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХААН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 7,981,728.00 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с хог хаягдлын төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-06-05 | |

Хэвлэсэн: 2024-10-29 13:15:46

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

# ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 5064975024 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Хот тохижилтын газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХААН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 6,747,901.76 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с хог хаягдлын төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-05-03 | |

Хэвлэсэн: 2024-10-29 13:15:31

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

# ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 5064975024 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Хот тохижилтын газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХААН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 3,878,377.46 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с хог төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-04-03 | |

Хэвлэсэн: 2024-10-29 13:15:17

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 5064975024 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Хот тохижилтын газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХААН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 902,104.04 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с хог хаягдлын төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-02-21 | |

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГАА

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,
Чингүнжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр,
Утас: 7000-3714, Факс: (976) 7000-3714
E-mail: TuulRBA@gmail.com

2024. 02. 02 № 04/93

танай 2024. 01. 22-ны № 2/16-т

"ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС"
ХХК-ИЙН БОРЛУУЛАЛТ,МАРКЕТИНГ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ О.ОДСАЙХАН
ТАНАА

Хаягдал усны дүгнэлт хүргүүлэх тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, "Премиум бьюлдинг материалс" ХХК-ийн 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 2/16 дугаар албан бичгийг үндэслэн Баянгол дүүрэг дэх бетон зуурмагийн үйлдвэрийн 2023 оны хаягдал усны дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хаягдал усны дүгнэлтээр тавигдсан шаардлагыг хангаж ажиллана уу.

Хувийг, Баянгол дүүргийн Засаг дарга, Баянгол дүүргийн Татварын хэлтэст.

Хавсралт 2 хуудастай, 2 хувь.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.НЯМДОРЖ

5632648
УЖА0053

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
"ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС " ХХК-ИЙН
ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2024 оны 02 дугаар сарын 02-ны/ний өдөр | Дугаар ХУ 24/ 17 | Улаанбаатар хот
Утас: 70003714, 70003716

**1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, цахим хаяг:**
- "Премиум бьюлдинг материалс" ХХК, Борлуулалт, маркетинг хариуцсан захирал О.Одсайхан, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А Шангри -Ла төв, Шангри-Ла Оффис 23 дугаар давхарт, 8810-6811, УБД- 9011720047, РД-6266258.

**2. Төслийн нэр, байршил:**
- "Премиум бьюлдинг материалс" ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр нь Баянгол дүүргийн 20-р хороо, Эрчим хүчний гудамж, ТЭЦ-4-р Цахилгаан станцын урд талд байрладаг.

**3. Хаягдал ус хаях цэгийн байршил, координат:**
- Ажилчдын унд ахуйн хэрэглээнээс гарч буй бохир усыг бетон доторлогоотой санд хуримтлуулж, автоцистернээр зөөвөрлөн хотын бохир усны өмнөд коллекторын зориулалтын худагт нийлүүлдэг. Бохир ус татан зайлуулах гэрээг "Ус сувгийн удирдах газар"-тай байгуулсан байна.

**4. Цэвэрлэгээний арга, түвшин:**
- Тус бетон зуурмагийн үйлдвэр нь эргэлтийн усан сантай ба нийт ус хэрэглээний 50 хувийг дахин ашигладаг.

**5. Хаягдал усны хэмжээ:**
- Тус компанийн 2023 оны хаягдал усны хэмжээг "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм" -оор тооцов. Жилд: 1'752.0 м$^3$/жил.

**6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:**
- Бохирдуулах бодисын хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Барилга хот байгуулалтын Сайдын 2019 оны А-816/218 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"-г үндэслэн тооцов. Ажилчдын тосгон - 1.5 кг/м$^3$.

**7. Ус бохирдуулсны төлбөр, тооцоо:**
- Унд, ахуйн хаягдал усны хэмжээ: 60 хүн х 80 л/хүн х 365 хон = 1'752.0 м$^3$

| **Хаягдал усны хэмжээ** (м$^3$) | **Жишиг хэмжээ** (кг/м$^3$) | **Бохирдуулах бодис** (кг) | **Ус бохирдуулсны төлбөр** (төг/кг) | **Нийт төлбөр,** төг |
|---|---|---|---|---|
| 1'752.0 м$^3$ | 1.5 | 2'628.0 | 50.0 | 131'400.0 |

- Ус бохирдуулсны төлбөр: 131'400.0 /Нэг зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун/ төгрөгийг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.10, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтад заасны дагуу 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор Баянгол дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ.

**8. Хууль тогтоомж, дүрэм журам, норм стандартын талаар зөвлөмж:**
- "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартаас давсан бохирдолтой хаягдал усыг төвлөрсөн сүлжээнд нийлүүлсэн тохиолдолд Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах нөхцөл үүсэхийг анхаарах;

- Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтад заасны дагуу хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийг Баянгол дүүргийн Засаг даргаар сунгуулах;

- Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

**9. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ:**

- Өмнөх оны хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд жилд нэг удаа хаягдал усны сорьц авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд хүргүүлэх;

- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтад заасны дагуу сав газрын усны мэдээллийн дэд сан бүрдүүлэхэд шаардлагатай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг, хаягдал усны шинжилгээний дүнгүүд, хаягдал усны төлбөр төлсөн баримтыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх.

**ХЯНАСАН:**
УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ АЛБАНЫ ДАРГА П.ЭНХБАЯР

**БОЛОВСРУУЛСАН:**
УНУАЗА-НЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.УРАНЧИМЭГ

| | |
|---|---|
| БАТЛАВ:<br>“ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС”<br>ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br><br>А.ГАНБОЛД | БАТЛАВ:<br>“ОЧИРТ СЭРГЭЭН БОСГОЛТ”<br>ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br><br>Г.ТӨМӨРСҮХ |

# ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ

PBM-PD-2024/0090

2024 оны 09-р сарын 02-ны өдөр №. ГЭҮ- Улаанбаатар хот

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээг (цаашид “**Гэрээ**” гэх)

Нэг талаас 6266258 тоот регистрийн дугаартай “Премиум Бьюлдинг Материалс” ХХК, (цаашид “Захиалагч тал” гэх), түүнийг төлөөлж Худалдан авалтын менежер албан тушаалтай З.Намуун,

Нөгөө талаас 5996856 регистрийн дугаартай “Очирт сэргээн босголт” ХХК, (цаашид “Гүйцэтгэгч тал”гэх), түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Г.Төмөрсүх, (хамтад нь “Талууд” гэх) нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч тал нь нийслэлийн Баянгол дүүргийн 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /16103/, Эрчим хүчний гудамж 57/1 тоотод байрлах Бетон зуурмагийн үйлдвэр-1 болон Баянзүрх дүүргийн 10-р хороо, Улиастайн гудамж, 101а тоотод байрлах Бетон зуурмагийн үйлдвэр-2 гамшгийн эрсдэлийн үнэлгээг (цаашид “Гэрээт ажил” гэх) гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэхтэй холбоотойгоор Талуудын хооронд үүсэх эрх, үүрэг, хариуцлагын харилцааг зохицуулахад оршино.

1.2 Гүйцэтгэгч тал нь Гэрээт ажил буюу гамшгийн эрсдэлийн үнэлгээг дараах төрлүүдээр холбогдох дүрэм, журам, стандартын шаардлагад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ:
  - 1.2.1 Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл
  - 1.2.2 Объектын гал түймрийн эрсдэл
  - 1.2.3 Үерийн эрсдэл
  - 1.2.4 Хүний үйл ажиллагаанаас үүсэх эрсдэл

1.3 Гүйцэтгэгч тал нь гэрээт ажлыг чанартай гүйцэтгэн Захиалагч талд шилжүүлж, Захиалагч тал нь уг ажлыг хүлээн авч, төлбөрийг энэхүү гэрээгээр тохиролцсон хэлбэр, хугацаанд төлнө.

1.4 Гүйцэтгэгч тал нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тухайн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл авсан байна.

1.5 Энэхүү гэрээний хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд дараах бичиг баримтуудыг хавсаргана. Үүнд: Хавсралт №01. Захиалагч болон Гүйцэтгэгчийн эрх зүйн баримт бичгүүд;
  1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (урд болон хойд тал)
  2. Гүйцэтгэгч талын тусгай зөвшөөрлийн хуулбар

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Ажил гүйцэтгэх хугацаа нь гэрээний урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгч талд шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 40 хоног байна.

2.2 Гүйцэтгэгч тал гэрээт ажлыг гүйцэтгэх үед цааш үргэлжлүүлэх боломжгүй буюу тодорхойгүй нөхцөл байдал, асуудал үүссэн буюу үүсэх магадлалтай тохиолдолд Захиалагч талд нэн даруй хугацаа алдахгүй албан ёсоор мэдэгдэж асуудлыг шийдвэрлэнэ.

2.3 Гэрээт ажлын гүйцэтгэлийн үйл явцаас шалтгаалан гэрээний үйлчлэх хугацааг гүйцэтгэгч талын саналаар 10 хоног хүртэл хугацаагаар сунгаж болох бөгөөд энэ талаарх мэдэгдлийг гүйцэтгэгч тал нь захиалагч талд мэдэгдсэнээр (цахимаар) гэрээний хугацаа сунгагдсанд тооцно.

## ГУРАВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

3.1 Гэрээт ажлын нийт төлбөр нь нийт 25,000,000 (Хорин таван сая) төгрөг байна. Энэ төлбөрт НӨАТ орсон.

3.2 Төлбөрийг дараах хуваарийн дагуу гүйцэтгэгч талд шилжүүлнэ.

3.2.1 Гэрээний үнийн дүнгийн 70 хувь болох 17,500,000 төгрөгийг урьдчилгаа хэлбэрээр гэрээ байгуулснаар шилжүүлнэ.

3.2.2 Гүйцэтгэгч тал нь гэрээнд дурьдсан 2 үйлдвэрийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгснөөр үлдэгдэл төлбөр болох 30 хувь буюу 7,500,000 төгрөгийг тус тус шилжүүлнэ.

3.3 Гэрээт ажлын хөлсийг захиалагч тал тухайн бүр гүйцэтгэгч талын нэхэмжлэхийг үндэслэн ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ.

## ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Гүйцэтгэгч тал нь дараах эрхийг эдлэнэ:

4.1.1 Гэрээнд заасны дагуу Захиалагч талаас гүйцэтгэсэн ажлын төлбөрөө шаардах;

4.1.2 Гэрээний хугацаанд Захиалагч талаас гүйцэтгэж буй ажилтай холбоотой шаардлагатай мэдээ, мэдээллийг авах;

4.1.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Захиалагч талаас шаардах.

4.2 Гүйцэтгэгч тал нь дараах үүргийг хүлээнэ:

4.2.1 Гүйцэтгэгч тал Гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаа, нөхцөлөөр, өөрийн материал, хэрэгслийг ашиглан чанарын болон мэргэжлийн өндөр түвшинд, алдаа дутагдал, доголдолгүй хийж гүйцэтгэн, гэрээнд заасан хугацаанд Захиалагчид хүлээлгэн өгөх;

4.2.2 Гэрээт ажлыг хүлээн авах үед эсвэл гомдлын шаардлага гаргах хугацаанд гүйцэтгэсэн ажил нь эрхийн болон биет байдлын доголдолтой, захиалагчийн шаардлагад нийцэхгүй, гэрээнд заасан зорилгоор ашиглах боломжгүй гэж захиалагч үзвэл гүйцэтгэгч түүний тогтоосон хугацаанд өөрийн зардлаар засах буюу шинээр гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд үүний улмаас захиалагч талд учирсан хохирлыг хариуцан арилгах;

4.2.3 Захиалагч талаас ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан санал, заавар, дүгнэлт өгвөл хүлээн авах, тусгах, биелүүлэх;

4.2.4 Гэрээт ажил гүйцэтгэхээр Захиалагч талаас авсан баримт, материал, тоног төхөөрөмжийг (хэрэв байгаа бол) гэрээт ажлыг хүлээлцэх үед бүрэн бүтэн буцаан өгөх;

4.2.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор Захиалагч талын ажлын байр, хашаа, барилгад нэвтрэх зэрэг тохиолдолд Захиалагч талын танилцуулсан дотоод дүрэм журмыг мөрдөх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг бүрэн хариуцаж, ажиллах хүчиндээ зохих зааварчилгаа өгөх, Захиалагчийн тавьсан шаардлагыг хүлээн авч ажиллах;

4.2.6 Гэрээт ажил гүйцэтгэхээр авсан материалуудыг зориулалтын дагуу ашиглах;

4.2.7 Гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор Захиалагч талын бизнесийн болон үйл ажиллагааны нууц, тухайн үед Захиалагч тал нууц гэж мэдээллэсэн бичиг баримт, мэдээ, мэдээллийг гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүйгээр задруулахгүй.
4.2.8 Гэрээт ажлын тайланг цаасаар болон цахим байдлаар Захиалагч талд хүлээлгэн өгөх үүрэгтэй.
4.2.9 Ажлын гүйцэтгэлийн чанар, аюулгүй байдал, доголдолгүй байдлыг захиалагч болон аливаа гуравдагч этгээдийн өмнө бүрэн хариуцах, түүнчлэн алдаатай, бүрэн бус гүйцэтгэлээс учирсан хохирол, зардлыг хариуцах;
4.2.10 Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээ байгуулахгүй байх;
4.2.11 Гэрээний зүйлийг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд тухайн ажлын үр дүн устсан, гэмтсэн тохиолдолд бий болох эрсдэлийг эрсдлийг дангаар хариуцах.

## ТАВ. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Захиалагч тал дараах эрхийг эдлэнэ:

5.1.1 Захиалагч тал нь гэрээнд заасан эрхээ өөрийн томилсон баг буюу ХАБЭА хариуцсан ажилтнаар дамжуулан хэрэгжүүлэх;
5.1.2 Гэрээт ажлын гүйцэтгэлийн болон ажлын үр дүнг шалгах явцад биет байдлын доголдол, эрхийн зөрчил илэрсэн тохиолдолд гэрээт ажлыг шинээр гүйцэтгэхийг Гүйцэтгэгч талаас шаардах;
5.1.3 Гэрээт ажлын гүйцэтгэлийн явцын тайланг талуудын тохиролцсон хугацаанд бэлтгэн ирүүлэхийг Гүйцэтгэгч талаас шаардах;
5.1.4 Гүйцэтгэгч тал ажлын талбайд ажил гүйцэтгэх явцад Захиалагч талын хөрөнгөнд ямар нэгэн байдлаар гэмтэл хохирол учруулсан тохиолдолд Захиалагч талын зүгээс ажлын цар хүрээ талбайн хэмжээгээр хохиролыг ноогдуулж, нэхэмжлэн авах
5.1.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гүйцэтгэгчээс шаардах.

5.2 Захиалагч тал дараах үүргийг хүлээнэ:

5.2.1 Гэрээнд заасан журмаар Гүйцэтгэгч талын нэхэмжлэхийг үндэслэн гэрээт ажлын хөлсийг төлөх;
5.2.2 Гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох мэдээ, мэдээлэл, баримт бичгийг Гүйцэтгэгч талын шаардсанаар хүлээлгэн өгөх;
5.2.3 Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гэрээт ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор гүйцэтгэгч талаас шаардсан бичиг баримтуудыг Гүйцэтгэгч талд тухай бүр хүлээлгэн өгөх;
5.2.4 Гүйцэтгэгч тал гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардагдах, Захиалагч талаас хамааралтай өгөгдөл, технологийн даалгавар, мэдээллийг тохиролцсон хугацаанд гарган өгч гэрээний хэрэгжилтийг шуурхай хангаж ажиллах;
5.2.5 Гэрээнд заасан бусад үүрэг.

## Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

6.1 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан бол учруулсан хохирлыг буруутай тал нь нөхөн төлөх үүрэгтэй.
6.2 Хохирол гэдэгт учирсан бодит хохирол, олох ёстой байсан орлого зэргийг ойлгоно.

6.3 Талууд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэнээс бусад нөхцөлд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэлгүй болно.
6.4 Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамааралтай (техник технологи, санхүү, бизнесийн нууц, ноу-хау гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд бичгээр болон аман хэлбэрээр задруулахгүй байх, хамгаалах үүргийг хугацаагүй хүлээнэ.
6.5 Талууд нь нууц мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахаас урьдчилан сэргийлэх ердийн боломжит бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

## Долоо. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл

7.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэж, МҮХАҮТ-аас гаргасан тухайн давагдашгүй хүчин зүйлийг нотлох баримтыг илгээх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
7.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал нь 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх аргаар шийдвэрлэх бөгөөд гэрээг аль нэг талын санаачлагаар цуцлаж болно.
7.3 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, хүчтэй салхи, ган зуд, хүчтэй аянга цахилгаан, далайн шуурга зэрэг байгалийн гамшгийн шинжтэй нөхцөл байдлууд, халдварт өвчний тархалт (тахал), цацраг идэвхит бодисын хордуулалт, хорио цээр, хил хаах, ажил хаялт, зэвсэгт мөргөлдөөн, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, дайн, дайн бүхий байдал, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт нийгмийн онцгой шинжтэй нөхцөл байдлууд зэрэг талуудын хүсэл зориг, хүчин чармайлтаас үл хамаарах нөхцөл байдлуудыг ойлгоно.

## Найм. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох

8.1 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ба уг нэмэлт, өөрчлөлтийг гагцхүү бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
8.2 Аль нэг тал гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа нөгөө талд бичгээр хүргүүлэх бөгөөд саналыг хүлээн авсан тал ажлын 3 хоногийн дотор хариу ирүүлнэ. Хариу ирүүлээгүй тохиолдолд саналыг хүлээн авахаас татгалзсанд тооцно.
8.3 Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас аль нэг тал гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бол аль нэг тал нөгөө талдаа 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэх бөгөөд талууд харилцан тохиролцож гэрээг цуцлаж болно.
8.4 Энэхүү гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа дуусгавар болсон, талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэсэн, аль нэг тал нь эрх зүйн чадамжгүй болсон нь тогтоогдсон эсхүл талууд гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгохоор тохиролцсон тохиолдолд гэрээ дуусгавар болно.

## Ес.Талуудын мэдээлэл

9.1 Гэрээний гүйцэтгэлтэй холбоотойгоор талууд хоорондоо харилцахдаа дараах этгээдүүдээр дамжуулан холбогдоно. Үүнд:

Захиалагч тал:

- Овог, нэр: З.Намуун
- Албан тушаал: Худалдан авалтын менежер
- Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19/А, Шангри-Ла Оффис Центр, 23 -р давхар
- Утас: 91119235
- Цахим шуудан: procurement@premiumbm.mn

Гүйцэтгэгч тал:

- Овог, нэр: Г.Төмөрсүх
- Албан тушаал: Гүйцэтгэх захирал
- Хаяг: БЗД, 6 хороо, Эрхэт оффис, 1002
- Утас: 99995681, 88109818
- Цахим шуудан: tumursukh2021@gmail.com

**Арав. Бусад зүйл**

10.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд уг маргааныг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

10.2 Гэрээнд талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг, зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

10.3 Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ нөгөө талынхаа бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

10.4 Энэхүү гэрээ нь талуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран хүчин төгөлдөр хэвээр байна.

10.5 Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг эх хувийг хадгалах бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

10.6 Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

**ДЭЭРХИЙГ ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОЖ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| Захиалагч талыг төлөөлж:<br>Премиум Бьюлдинг Материалс ХХК-ийн<br>Худалдан авалтын албаны менежер<br>З.Намуун<br>……………………………… | Гүйцэтгэгч талыг төлөөлж:<br>“Очирт сэргээн босголт” ХХК-ийн<br>Гүйцэтгэх захирал<br>Г.Төмөрсүх<br>……………………………… |

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

# СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2024/ Ц-125 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : “Премиум Бьюлдинг” ХХК |
| Сорьц авсан хүний нэр, албан тушаал | : М. Дарханбаатар, 88105834 |
| Сорьцын тоо, төрөл | : 1, ус |
| Сорьц авсан огноо | : 2024.06.14 |
| Сорьцын тодорхойлолт | : Ундны ус |
| Шинжилгээний аргын стандарт | **MNS 6836:2020, MNS 6833:2020**<br>**MNS 1097:2023, MNS 6779:2019**<br>**MNS 6834:2020, MNS ISO 6878:2001**<br>**MNS 4430:2005, MNS 6272: 2011** |
| Шинжилсэн огноо | : 2024.06.14-2024.06.28 |
| Хуудасны тоо | : 1 /2 |
| Үр дүн | : 1 |

| Сорьц авсан цэг | Ж/б мг/л | ПИЧ мг/л | $NH_4$ мг/л | $NO_2$ мг/л | $NO_3$ мг/л | $PO_4$ мг/л | Fe мг/л | F мг/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| БГД, 20-р хороо | 0.8 | 1.5 | 0.03 | 0.006 | 6.56 | 0.016 | 0.01 | 1.42 |
| **MNS 0900:2018** | **-** | **-** | **1.5** | **1.0** | **50** | **3.5** | **0.3** | **0.7-1.5** |

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, ПИЧ Перманганатын Исэлдэх Чанар

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: Б.Анужин

Шалгасан ахлах шинжээч: С.Отгонжаргал

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч: Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

# СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2024/ Ц-125

Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Премиум Бьюлдинг" ХХК

Сорьц авсан хүний нэр, албан тушаал : М. Дарханбаатар, 88105834

Сорьцын тоо,төрөл : 1, ус

Сорьц авсан огноо : 2024.06.14

Сорьцын тодорхойлолт : Ундны ус

Шинжилгээний аргын стандарт **MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999**
**MNS 1097:2023, MNS 4424:2005**
**MNS 6832:2020**

Шинжилсэн огноо : 2024.06.14-2024.06.28

Хуудасны тоо : 2 /2

Үр дүн : 1

| Сорьц авсан цэг | pH | EC мкСи/см | $SO_4$ мг/л | Cl мг/л | Ca мг/л | Mg мг/л | Na+K мг/л | $HCO_3$ мг/л | Эрд мг/л | Хат мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| БГД, 20-р хороо | 6.84 | 260 | 39.9 | 12.4 | 36.9 | 2.2 | 17.5 | 93.9 | 203 | 2.02 |
| **MNS 0900:2018** | **6.5-8.5** | **1000** | **500** | **350** | **100** | **30** | - | - | - | **7.0** |

Тайлбар: EC - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэсжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: Б.Анужин

Шалгасан ахлах шинжээч: С.Отгонжаргал

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч: Б.Алтантуяа

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 08

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohztl@gmail.com

# СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2024/138-139
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг,утас : "Премиум бюлдинг материалс"ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 2, хөрсний сорьц
Сорьц авсан огноо : 2024.05.13
Сорьцын тодорхойлолт : БГД,20-р хороо
Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022
Шинжилсэн огноо : 2024.05.16
Хуудасны тоо : 1/1

Үр дүн

| № | Сорьц авсан цэгийн нэр | Кадьми (Cd) | Хар тугалга (Pb) | Мөнгөн ус (Hg) | Хром (Cr) | Цайр (Zn) | Зэс (Cu) | Стронци (Sr) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | | | | | | |
| 1 | Оффис | <0.05 | 16 | <0.005 | <0.5 | 108 | 29 | 327 |
| 2 | Үйлдвэр орчим | 0.2 | 15 | <0.005 | <0.5 | 69 | 30 | 361 |
| **MNS 5850:2019/ ЗДХ/** | | **3** | **100** | **2** | **150** | **300** | **100** | **800** |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Ахлах шинжээч Б.Даваасүрэн

Хянаж баталгаажуулсан: Ахлах шинжээ Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

## ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
## БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohztl@gmail.com


# СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2024/140 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг,утас | : "Премиум бюлдинг материалс"ХХК |
| Сорьц авсан хүний нэр, албан тушаал | : Д.Сувд агаарын хэсэг |
| Сорьцын тоо, төрөл | : 1, хөрсний сорьц |
| Сорьц авсан огноо | : 2024.05.13 |
| Сорьцын тодорхойлолт | : БЗД,10-р хороо |
| Шинжилгээний аргын стандарт | : САЗ A01:2022 |
| Шинжилсэн огноо | : 2024.05.16 |
| Хуудасны тоо | : 1/1 |

Үр дүн

| № | Сорьц авсан цэгийн нэр | Кадьми (Cd) | Хар тугалга (Pb) | Мөнгөн ус (Hg) | Хром (Cr) | Цайр (Zn) | Зэс (Cu) | Стронци (Sr) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | | | | | | |
| 1 | Үйлдвэр орчим | <0.05 | 18 | <0.005 | <0.5 | 29 | 30 | 638 |
| | **MNS 5850:2019/ ЗДХ/** | **3** | **100** | **2** | **150** | **300** | **100** | **800** |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Ахлах шинжээч Б.Даваасүрэн

Хянаж баталгаажуулсан: Ахлах шинжээч Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com


# СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2024/А-87 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : "Премиум Бьюлдинг Материалс" ХХК |
| Сорьцын авсан хүний нэр, албан тушаал | : Д.Сувд агаарын хэсэг |
| Сорьцын тоо, төрөл | : 2 агаар, 2 дуу чимээ |
| Сорьц авсан огноо | : 2024.05.13 |
| Сорьцын тодорхойлолт | : Улаанбаатар хот БГД 20-р хороо Бетон зуурмагийн үйлдвэр |
| Шинжилгээний аргын стандарт | : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 MNS 5002:2000, САЗ А07-2016 |
| Шинжилсэн огноо | : 2024.05.17 |
| Хуудасны тоо | : 1/1 |

Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м$^3$ | | | ДБА |
| 1 | Үйлдвэр орчим | V/13 | 11:00 | 0.010 | 0.028 | 0.710 | 60 |
| 2 | Оффис орчим | V/13 | 11:25 | 0.009 | 0.019 | 0.362 | 48 |
| **Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016, Хүлцэх агууламж (20 минутын хэмжилт)** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч: Б.Алтантуяа

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

# СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2024/A-87 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : "Премиум Бьюлдинг Материалс" ХХК |
| Сорьцын авсан хүний нэр, албан тушаал | : Д.Сувд агаарын хэсэг |
| Сорьцын тоо, төрөл | : 1 агаар, 1 дуу чимээ |
| Сорьц авсан огноо | : 2024.05.13 |
| Сорьцын тодорхойлолт | : Улаанбаатар хот БЗД 10-р хороо Бетон зуурмагийн үйлдвэр |
| Шинжилгээний аргын стандарт | : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 MNS 5002:2000, САЗ A07-2016 |
| Шинжилсэн огноо | : 2024.05.17 |
| Хуудасны тоо | : 1/1 |

Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м$^3$ | | | ДБА |
| 1 | Үйлдвэр орчим | V/13 | 13:15 | 0.011 | 0.024 | 0.226 | 74 |
| **Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016, Хүлцэх агууламж (20 минутын хэмжилт)** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч: Б.Алтантуяа

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 08 ҮИТ0235

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

# ХУВАНЦАР САВ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 5 сарын 21 өдөр **SESL-24/....** Улаанбаатар хот

Энэхүү хуванцар сав нийлүүлэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас, "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК (РД:6990916) /цаашид "Худалдан авагч" гэх/, түүнийг төлөөлж Ч.Атар......

Нөгөө талаас, "Дуулар Алтантогос"(РД:ШГ80122204) /цаашид "Нийлүүлэгч" гэх/, түүнийг төлөөлж ...................................... /хамтад нь "Талууд" гэх/ нар харилцан тохиролцож байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээний зорилго нь нийлүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан, худалдан авагчийн шаардлагыг хангахуйц PET1 тэмдэглэгээ бүхий ундаа, усны хуванцар сав, бүх төрлийн лаазыг хүлээлгэж өгөх, худалдан авагч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх болон бусад харилцааг зохицуулахад оршино.

## ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО, ХУГАЦАА

2.1 1кг хуванцар савны үнэ 400 (дөрвөн зуу), цэг дээр хүлээн авах үнэ 600 (зургаан зуу) төгрөг, лааз 1кг нь 1000₮ тус тус байна.

2.2 Нийлүүлэгч төлбөр төлөгдсөнөөс хойш ажлын 3 хоногийн дотор и-баримтыг шивнэ.

2.3 ***Төлбөр төлөх нөхцөл:*** Хуванцар савыг хүлээлгэж өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.

2.4 ***Төлбөр төлөх данс:*** Нийлүүлэгчийн 5033083041 тоот Алтантогос дансны нэртэй "Хаан банк" банкны дансаар төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.

2.5 ***Гэрээний хугацаа:*** Энэхүү гэрээ нь баталгаажсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

2.6 Гэрээний хугацаа дуусах үед талууд ямар нэгэн санал гаргаагүй бол гэрээ дахин 1 жилээр сунгагдана.

2.7 Гэрээний төлбөрийг нэмэх, хасах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдэх бөгөөд зөвхөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинэ төлбөрийн нөхцөл болон дүн баталгаажна.

2.8 Нийлүүлэгчийн хүлээлгэж өгсөн хуванцар савнууд дунд өөр төрлийн хуванцар сав болон хэт бохирдсон хуванцар сав нь 2кг–аас хэтэрсэн тохиолдолд энэ талаар мэдээллийг Худалдан авагч нь Нийлүүлэгчид мэдэгдэж нийт хэмжээгээр хорогдолд тооцож төлбөрийг төлнө.

## ГУРАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

3.1 **Нийлүүлэгчийн хүлээх үүрэг**

3.1.1 Нийлүүлэгч нь зөвхөн PET1 тэмдэглэгээ бүхий ундаа, усны хуванцар савыг цуглуулж, хүлээлгэж өгөх бөгөөд бусад төрлийн хуванцар савыг холихгүй байх үүрэгтэй.

3.1.2 Нийлүүлэгч нь хэт бохирдсон болон зориулалтын бусаар ашигласан савнуудыг /айраг, сүү, цагаан идээний төрлийн зүйл хийсэн болон хэт бохирдсон/ тээвэрлэхээс өмнө ангилан ялгасан байх үүрэгтэй.

3.1.3 Бүтээгдэхүүн тээвэрлэхээс ажлын 2 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх бөгөөд машинд шууд ачихад бэлэн болгосон байна.

3.1.4 Худалдан авагчийн хүлээлгэн өгсөн хуванцрын уутыг зориулалтын дагуу ашиглах бөгөөд гэрээ цуцлах тохиолол хүлээн авсан тоо хэмжээгээр буцааж өгөх үүрэгтэй.

3.1.5 Нийлүүлэгч нь хуванцар цуглуулах уутыг дүүргэсний дараа дуудлага өгнө.

3.1.6 Машинд ачих зам талбайг чөлөөлж, чөлөөтэй нэвтрэх боломжоор хангах, гэмтэж болзошгүй эд хөрөнгийг холдуулна.

3.1.7 Нийлүүлэгч өөрсдийн тээврийн хэрэгсэлээр түүхий эд хүлээн авах цэгт хүргэх тохиолдолд тухай бүр харицсан төлөөлөгчид утсаар мэдэгдэж машины дугаарыг бүртгүүлнэ.

**3.2 Худалдан авагчийн хүлээх үүрэг**

3.2.1 Худалдан авагч нь өөрсдийн зориулалтын төхөөрөмжөөр жинлэж баталгаажсан хэмжээгээр тооцож энэ гэрээний 2.3-т заасан хугацаанд төлбөрийг төлөх үүрэгтэй.

3.2.2 Худалдан авагч нь дуудлага ирүүлсэнээс хойш ажлын 2 хоногийн дотор тээвэрлэнэ.

3.2.3 Нийлүүлэгчид цуглуулах хуванцар савны талаар мэдээлэл болон гарын авлага өгөх үүрэгтэй.

**ДӨРӨВ. БУСАД**

*4.1 Мэдэгдэл.* Энэхүү гэрээтэй холбоотой аливаа мэдэгдлийг бичгээр үйлдэж, биечлэн эсхүл баталгаат шуудангаар Гэрээнд заасан хаягаар хүргүүлнэ.

*4.2 Маргаан шийдвэрлэх.* Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Шүүхээр шийдвэрлүүлнэ.

*4.3 Гэрээ цуцлах:* Аль нэг тал гэрээний хугацаанаас өмнө гэрээ цуцлах бол нөгөө талдаа ажлын 10 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

**ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ**

"ЭС И ЭС ЭЛ СМАРТ СОЛЮШН" ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

________________/Ч. АГИЙМАА/

Харилцагч хөгжүүлэх мэргэжилтэн

________________/ /

Хаяг: Баянзүрх дүүрэг, 1 хороо, 11 хороолол, Токиогийн гудамж 2-4 тоот

Утас: 76107711,

И-мэйл:

**НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ**

"ПБМ" ххк захиралтай

Д. Алтантогос

________________/ /

БГД-20р хороо

эрчим хүчний гудамж

Хаяг:

Утас: 95013138

И-мэйл:

PREMIUM
Building Materials

# ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 02 өдөр Дугаар 23/А-12 Улаанбаатар хот

Химийн бодистой харьцаж ажиллах, хадгалах журам батлах тухай

Монгол Улсын Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Премиум Бьюлдинг Материалс ХХК -н |компани| Химийн бодистой харьцаж ажиллах, хадгалах журмыг хавсралт №1 баталсугай.
2. Журам шинэчлэн батлагдсантай холбоотойгоор 2022 он 08 сар 23 өдөр 12|А-026 тоот тушаалаар батлагдсан журмыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Химийн бодистой харьцаж ажиллах, хадгалах журмыг 2023 он 05 сар 04 өдрөөс эхлэн мөрдөж ажилласугай.
4. Журмыг нийт ажилтнуудад танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ХАБЭА,БО алба менежер |Г.ХАСБААТАР| -т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ П.МӨНХНАСАН

Премиум Бьюлдинг Материалс ХХК-ийн захирлын
2023 оны 5 сарын 2 өдрийн
23/А-12 тоот тушаалын Хавсралт

PREMIUM
Building Materials

# ХИМИЙН БОДИСТОЙ ХАРЬЦАЖ АЖИЛЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

| | |
|---|---|
| ДУГААР | ХАБЭА,БО - 008 |
| НУУЦЫН ЗЭРЭГ | С1 |
| ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ | Премиум Бьюлдинг Материалс ХХК |
| ТАНИЛЦАХ | Компанийн нийт ажилтан, туслан гүйцэтгэгч |
| ХАРИУЦАХ НЭГЖ | ХАБЭА,БО-ны алба |

| | | |
|---|---|---|
| БОЛОВСРУУЛСАН | Гарын үсэг | |
| | Нэр, албан тушаал | Г.Хасбаатар, ХАБЭА,БО менежер |
| БАТЛАВ | Гарын үсэг | |
| | Нэр, албан тушаал | П.Мөнхнасан, захирал |
| ХЯНАСАН | Гарын үсэг | |
| | Нэр, албан тушаал | |

ӨӨРЧЛӨЛТ

| Хувилбар | Тэмдэглэл |
|---|---|
| 1.0 | 2018- оны 07 сарын 16 өдөр шинээр боловсруулав. |
| 2.0 | 2022 оны 08 сарын 10 өдөр өөрчлөлт оруулав. |
| 3.0 | 2023 оны 05 сарын 02 өдөр өөрчлөлт оруулав. |

Хэвлэсэн: 2024-10-16 15:14:41

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

# ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 458007404 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Ус сувгийн удирдах газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 127,644.00 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с бохир соруулах үйлчилгээний төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-08-23 | |

Хэвлэсэн: 2024-10-16 15:13:25

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 458007404 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Ус сувгийн удирдах газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 387,354.00 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с бохир соруулсан төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-05-29 | |

Хэвлэсэн: 2024-10-16 15:12:09

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

# ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 5003001028 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Ус сувгийн удирдах газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХААН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 255,288.00 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с 0224-ны бохир соруулсан төлбөр BP#1 | |
| Гүйлгээний огноо: | 2024-02-29 | |

Хэвлэсэн: 2024-10-16 15:08:09

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК Сайн сайхныг санхүүжүүлнэ

# ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 404001620 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Ус сувгийн удирдах газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 44,712.95 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с код:22098500 Ус цэвэршүүлсэний төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-01-24 | |

Хэвлэсэн: 2024-10-16 15:15:37

PREMIUM Building Materials

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

# ИНТЕРНЕТ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

| | Шилжүүлэгчийн мэдээлэл | Хүлээн авагчийн мэдээлэл |
|---|---|---|
| Дансны дугаар: | 8115101408 | 5003001028 |
| Эзэмшигчийн нэр: | Премиум Бьюлдинг Материалс ХХК | Ус сувгийн удирдах газар |
| Банк: | ГОЛОМТ БАНК /Банкгейтвэй/ | ХААН БАНК |
| Гүйлгээний төлөв: | Амжилттай | |
| Гүйлгээний дүн: | 686,664.00 | |
| Лавлах дугаар: | 77778080 | ХУУЛБАР ҮНЭН |
| Гүйлгээний утга: | 6266258-с усуг төлбөр | |
| Гүйлгээний огноо: | 2024-09-27 | |

Төлсөн баримт ×

# МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

## ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1241002513108

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 98100172226 / 6266258 |
| Татвар төлөгчийн нэр: | Премиум бьюлдинг материалс |
| Татварын төрөл: | 01030722 - Ус бохирдуулсны төлбөр |
| Харьяалах татварын алба: | Том татвар төлөгчийн газар / Улсын төвлөрсөн |
| Төлсөн дүн: | 96,040.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-10-15 10:39:01.0 |
| Гүйлгээний утга: | 1241002513108;98100172226;5476992;;98100172226;99999999;8115101408;ПРЕМИ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС;Golomtbank-Online;99999999 |
| Татварын данс: | ТЕГ.Ус бохирдуулсны төлбөр - 100900000417 |
| Төлөлтийн хэлбэр: | Голомт банк |

Хэвлэх

Төлсөн баримт ×

# МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

## ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1240403944995

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 98100172226 / 6266258 |
| Татвар төлөгчийн нэр: | Премиум бьюлдинг материалс |
| Татварын төрөл: | 01030722 - Ус бохирдуулсны төлбөр |
| Харьяалах татварын алба: | Том татвар төлөгчийн газар / Улсын төвлөрсөн |
| Төлсөн дүн: | 9,980.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-04-19 11:45:21.0 |
| Гүйлгээний утга: | 1240403944995;98100172226;5476992;;98100172226;99999999;8115101408;ПРЕМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС;Golomtbank-Online;99999999 |
| Татварын данс: | ТЕГ.Ус бохирдуулсны төлбөр - 100900000417 |
| Төлөлтийн хэлбэр: | Голомт банк |

Хэвлэх

Төлсөн баримт ×

# МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

## ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1240703350687

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 98100172226 / 6266258 |
| Татвар төлөгчийн нэр: | Премиум бьюлдинг материалс |
| Татварын төрөл: | 01030722 - Ус бохирдуулсны төлбөр |
| Харъяалах татварын алба: | Том татвар төлөгчийн газар / Улсын төвлөрсөн |
| Төлсөн дүн: | 92,380.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-07-19 14:33:23.0 |
| Гүйлгээний утга: | 1240703350687;98100172226;5476992;;98100172226;99999999;8115101408;ПРЕМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС;Golomtbank-Online;99999999 |
| Татварын данс: | ТЕГ.Ус бохирдуулсны төлбөр - 100900000417 |
| Төлөлтийн хэлбэр: | Голомт банк |

Хэвлэх